Батлав: БОУАӨЯ-ны Хүрээлэн буй орчны бодлогын хэрэгжилтийн газрын дарга

____________________Г.Энхмөнх

Зөвшөөрч, хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн: "Энержи Ресурс" ХХК-ийн Гүйцэтгэх захирал

____________________(Д.Энхбат)

# УХАА ХУДАГ ТӨСӨЛ

## ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЦОГТЦЭЦИЙ СУМЫН "УХАА ХУДАГ" ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧИЙН 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААР: **MV-011952**
АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР: **2887746**

Хянасан:

БОУАӨЯ-ны ХБОБХГ-ын ахлах шинжээч ______________________Ц.Жаргалнэмэх

Боловсруулсан:

"Энержи Ресурс" ХХК-ийн Байгаль орчны ахлах менежер __________________П.Батболд

2026 он

**АГУУЛГА**


**1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА ... 1**
- 1.1. Ухаа худаг нүүрсний уурхай ... 1
- 1.2. Нүүрс баяжуулах үйлдвэр ... 2
- 1.3. Цахилгаан станц ... 3
- 1.4. Ус хангамж ... 4
- 1.5. Шатахууны агуулах ... 5
- 1.6. Уурхайн ажиллагсдын хотхон ... 6
- 1.7. Ухаа худаг Гашуун сухайт, Баруун наран Ухаа худаг чиглэлийн авто зам ... 6
- 1.8. Цагаан хад нүүрс ачиж буулгах талбайн үйл ажиллагаа ... 7
- 1.9. Ухаа худаг төмөр замын терминал ... 7

**2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БАЙГАА ГАЗАР НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА ... 8**
- 2.1. Ухаа худаг орчмын газар нутгийн төлөв байдал газар зүйн онцлог ... 8
- 2.2 Нийгэм эдийн засгийн төлөв байдал ... 9

**3. УХАА ХУДАГ ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ ТҮҮНИЙ ГОЛ ЗОРИЛТ ... 14**

**4. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ ... 15**
- 4.1. Ухаа худаг төслийн сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө ... 15
- 4.2. Цагаан хад орчмын сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө ... 19

**5. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ ... 21**
- 5.1. Уурхайн хаягдлын овоолгын нөхөн сэргээлт ... 23
- 5.5. Тэрбум мод хөдөлгөөний хүрээнд мод сөөг тарих ... 23

**6. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ ... 24**

**7. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ ... 26**

**9. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ ... 27**

**9. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ ... 28**

**10. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ ... 31**
- 10.1. Хог хаягдлын менежментийн үндсэн зарчим ... 33

**11. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ ... 35**

**12. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР ... 37**
- 12.1 Газрын доорхи усны хяналт шинжилгээ ... 37
- 12.2. Агаарын чанарын хяналт шинжилгээ ... 38
- 12.3. Хөрсний судалгаа ... 39
- 12.4. Ургамал, Амьтны аймгийн судалгаа ... 39

**13. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ХУВААРЬ ... 40**

**14. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТӨСВИЙН ЗАДАРГАА ... 41**

# 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжил, бизнест тодорхой хувь нэмэр оруулах, нэн ялангуяа нүүрс, нүүрсэн химийн бүтээгдэхүүний олборлолт, үйлдвэрлэл, борлуулалтыг нэмэгдүүлэх, энэ чиглэлээр дэлхийн зах зээлд баттай байр сууриа эзлэх эрхэм зорилготойгоор “Энержи Ресурс” ХХК нь 2005 оны 4-р сарын 22-нд байгуулагдсан үндэсний хөрөнгө оруулалттай компани юм. Тус компани нь “Ухаа худаг” төслийн хүрээнд Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт байрлах Ухаа худаг коксжих нүүрсний ордыг 2009 оноос олборлож эхэлсэн нь коксжсон нүүрсний зорилтот зах зээлд хүргэхэд томоохон алхам болсон. “Энержи Ресурс” ХХК нь өндөр хөгжилтэй орнуудад мөрддөг олон улсын стандартыг эх орондоо нэвтрүүлж, бодит ажил хэрэг болгон хариуцлагатай уул уурхайн жишиг тогтоохыг зорьж, Монгол улсад өрнөж буй их бүтээн байгуулалтад өөрийн хувь нэмэрээ оруулан ажиллаж байна. Тус компани нь Ухаа худаг төслийн хүрээнд явагдаж байгаа бүхий л үйл ажиллагааны явцад байгаль орчныг хамгаалах багц хууль, стандартууд, Олон улсын стандартыг даган мөрдөж, төслийн үйл ажиллагааны явцад гарч байгаа сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, байгаль орчныг хамгаалах зорилготойгоор ажилладаг. “Энержи Ресурс” компани нь 2007 онд Ухаа Худагийн ордын ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрлийг эзэмших болсноор ордыг ашиглах ТЭЗҮ, Баяжуулах үйлдвэрийн ТЭЗҮ зэргийг боловсруулан батлуулж, 2008 оны 10 сараас ашиглалтын өмнөх үйл ажиллагааны гэрээнийн дагуу уулын бэлтгэл ажлыг эхлүүлсэн ба 2009 оны 4 сард улсын комисс Ухаа Худагийн уурхайг байнгын ашиглалтанд хүлээж авснаар хөрс хуулалт, нүүрс олборлолтын ажлыг эхлүүлсэн.

2026 оны ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөлтөөр 10.45 сая тн нүүрс олборлоно.

MV-011952 тусгай зөвшөөрлийн булангийн цэгүүдийн солбицолууд

| Дугаар | X | У |
|---|---|---|
| 11952A - 4 | 4835630.651 | 536106.290 |
| 11952A - 1 | 4839519.390 | 536085.354 |
| 11952A - 2 | 4839364.841 | 543699.684 |
| 11952A - 3 | 4835676.639 | 543725.328 |

“Энержи Ресурс” компани нь Монгол улсын хөгжил дэвшил, үйлвэржилт, шинэчлэлд тодорхой хувь нэмэр оруулах, “Ухаа Худаг” нүүрсний ордыг цогц байдлаар ашиглах зорилтын хүрээнд уурхайн нүүрс олборлолтын үйл ажиллагаатай зэрэгцүүлэн жилд 15 сая нүүрс хүлээн авч баяжуулах үйлдвэр, 18 Мвт конденсатын цахилгаан станц, хаягдлыг усгүйжүүлэх үйлдвэр, уурхайн ажиллагсадын “Галлерей кемп”, гүний ус олборлох худаг, ус цэнгэгжүүлэх байгууламж, Ухаа худаг-Гашуун сухайтын чиглэлийн 245 км хатуу хучилттай зам, 5000 хүн ам оршин суух “Цэций” хороолол орон сууц, хоногт 1200 м$^3$ ус цэвэршүүлэх цэвэрлэх байгууламж болон бусад ахуйн барилгыг барьж ашиглалтанд оруулсан.

## 1.1. Ухаа худаг нүүрсний уурхай

“Энержи Ресурс” ХХК нь уурхайн олборлолтын чиглэлээр ашигт малтмалын эрэл хайгуул, нөөцийн үнэлгээ, уурхайн урт, дунд болон богино хугацааны төлөвлөлт, ISO, GB, MNS стандарт шаардлагуудыг хангасан нүүрсний чанарын бүрэн хэмжээний судалгаа, уул уурхайн хүнд машин механизмын засвар үйлчилгээ, ашигт малтмалын олборлолт зэрэг 10 гаруй чиглэлд үйл ажиллагаа явуулж байна. Уурхайд үндсэн техникүүдийн хувьд Leibherr 996, Leibherr 9400, Hitachi 3600, Leibherr 9250 загварын экскеваторууд ашиглагдаг. Уурхайн дотоод тээвэрлэлтэнд Caterpillar фирмийн автосамосвалуудыг ашигладаг бөгөөд 2026 оны 2-р сараас автосамосвалын тоог 10-р бууруулж ажиллана. Уурхайн парк бүрдүүлэгч нийт экскаваторын тоо 2026 онд 21 байх ба уурхай 12 цагийн 2 ээлжээр, 24 цагийн турш ажилладаг бөгөөд үйл ажиллагаа хэвийн үед 700 орчим хүн ажилладаг. Уурхайн өрөмдлөг тэсэлгэний ажлыг Мера ХХК болон Сток Бласт ХХК гэрээгээр гүйцэтгэдэг ба уурхайн үйл ажиллагаанд Вертекс майнинг партнер ХХК болон Эрч майнинг ХХК- гэрээгээр ажиллж байна.



Зураг 1.1.1. *Нүүрсний уурхай*

## 1.2. Нүүрс баяжуулах үйлдвэр

Ухаа Худаг төслийн хүрээнд жилд тус бүр 5 сая тонн нүүрс угааж, боловсруулах хүчин чадалтай 3 модуль бүхий Нүүрс баяжуулах үйлдвэр Австралийн Седжмен компанийн зураг төслөөр баригдсанаас эхний модуль 2011 оны 6-р сард, 2-р модуль 2012 эхний хагаст ашиглалтанд оруулж жилдээ 10 сая тонн нүүрс хүлээн авч баяжуулж байгаа ба 3-р модулийг 2013 оны 7 сард оруулснаар жилийн хүчин чадал 15 сая тонн болж өргөжсөн. 2026 онд Ухаа худаг уурхайгаас 10 сая тонн, Баруун наран уурхайгаас 4.082 сая тонн хүртэл тэжээл хүлээн авч боловсруулахаар төлөвлөж байна.



*Зураг 1.2. Нүүрс баяжуулах үйлдвэр*




Зураг 1.3. *Нүүрс баяжуулах үйлдвэрийн технологийн схем*

### ***1.2.1***. *НБҮ-ийн хаягдлыг усгүйжүүлэх үйлдвэр*

Нүүрс баяжуулах үйлдвэрийн хаягдлыг усгүйжүүлэх ажиллагаанд шинэ техник технологийг ашиглан байгаль орчинд ээлтэй нөхцлөөр шийдвэрлэхээр Нүүрс баяжуулах үйлдвэрийн Хаягдлыг усгүйжүүлэх байгууламжийг барьж байгуулан 2013 оны 12-р сард ашиглалтад оруулсан.

Уг байгууламж нь баяжуулах үйлдвэрийн хаягдлыг усгүйжүүлж, гарсан усны 67%-85%-ийг эргүүлэн ашиглахад зориулагдсан үйлдвэр юм. Үйлдвэрт 8 ширхэг усгүйжүүлэх төхөөрөмжийг суурилуулсан ба нэг төхөөрөмж нь цагт 86 $м^3$ хаягдлыг базаж 65 $м^3$ шүүгдсэн ус, 21 тн хуурай хаягдал болгон ялгана. Шүүгдсэн усыг технологийн шугаманд эргүүлэн ашигладаг. 2018 онд уг үйлдвэрийн технологийг сайжруулж даралтат шүүлтүүрийн / Filter press/ технологийг нэвтрүүлснээр үйлдвэрийн хаягдал усыг эргүүлэн ашиглах хэмжээг нэмэгдүүлсэн. 2025 оны 4-р сард НБҮ-ийн хаягдлыг усгүйжүүлэх үйлдвэрийн өргөтгөлийг ашиглалтад оруулсан 2 ш фильтр пресс нэмэлтээр суурьуулж хүчин чадлыг нэмэгдүүлсэн.




Зураг 1.4. *Хаягдлыг усгүйжүүлэх үйлдвэрийн технологийн схем*

### *1.2.2. Химийн бодисын нэгдсэн агуулах*

Химийн бодис, урвалж хадгалах зориулалттай, MNS 6458:2014 стандартад бүрэн нийцсэн 740$м^2$ талбай бүхий агуулахын барилгыг 2020 онд барьж ашиглалтанд оруулсан.



Зураг 1.4. *Химийн бодисын агуулах*

## 1.3. Цахилгаан станц

“Энержи Ресурс” ХХК-ний Ухаа худаг коксжих нүүрсний ордыг түшиглэн 18 МВт-ын хүчин чадалтай цахилгаан станц барьж, 2011 оны 9 сарын 24-нд ашиглалтанд оруулсан. Тус станц нь уурхайн болон дэд бүтцийн төслүүдийн эрчим хүчний бүхий л хэрэгцээг хангахаас гадна Өмнөговь аймгийн Цогтцэций сумыг цахилгаанаар найдвартай хангаж байна. Монголдоо анх удаа дотоодын чадварлаг инженерүүдийн ур ухаанаар боссон энэхүү цахилгаан станц говь нутгийн байгалийн онцлогт нэн тохиромжтой хуурай хөргөлтийн систем, шаталтын үр дүнд үүссэн байгаль орчинд хортой үнсийг цахилгаан ионжих аргаар ялгах цахилгаан фильтер, усны бага хэрэглээ гээд

технологийн олон давуу талыг агуулсан тул одоогоор Монголд ажиллаж буй бусад цахилгаан станцуудтай харьцуулахад усыг 4-5 дахин хэмнэх боломжтой. 2026 онд нийт 130.079 сая кВт.ц/жил эрчим хүч үйлдвэрлэхээр төлөвлөж байна. Үйлдвэрлэлийн бүс болон ажилчдын хотхоны дулаан хангамжийг тусдаа халаалтын зуухнуудаар шийддэг.



Зураг 1.5. *Цахилгаан станц*




Зураг 1.6. *Цахилгаан станцын технологийн схем*

### 1.4. Ус хангамж

Ухаа Худаг уурхайн цогцолборын үйлдвэрлэлийн болон ахуйн хэрэглээний ус хангамжийн ухаалаг, дэвшилтэт системийг бий болгох ажил 2008 оны 1-р сараас эхэлж улмаар 2011 оны 6-р сард ашиглалтад орсон. Ингэхдээ цэвэр усны нөөцөөр хомс говь нутгийн онцлогийг дээд зэргээр харгалзсан, усыг 100 хүртэлх хувь дахин ашиглах, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, дэвшилтэт технологид суурилсан болно.

Уурхайн нийт төслүүдийн усны хэрэгцээг хангаад зогсохгүй Өмнөговь аймгийн Цогтцэций сумыг эрүүл ахуйн шаардлагад нийцсэн, ундны цэвэршүүлсэн усаар хангаж буй ус хангамжийн систем нь 56,000 куб метрийн багтаамжтай усан сан, насос станц болон иж бүрэн автомат хяналтын систем гээд технологийн онцлог шийдэл бүхий хэсгүүдээс бүрдэл болдог.

2026 онд үүрхайн ажиллагсдын “Цэций” хорооллийн тэлэлттэй холбогдуулан ундны ус хангамжийн системд өргөтгөл хийхээр төлөвлөсөн.

#### *1.4.1. Ус хангамжийн систем*

Төслийн хэрэгцээнд Наймантын хотгорын болон Наймдайн хөндийн гэсэн хоёр үндсэн ус хангамжийн системийг байгуулснаас ашиглаж байгаа ба нийт 22 гүний худагтай.




Зураг 1.7. *Ус хангамжийн ерөнхий схем зураг*

### ***1.4.2.*** *Нийтийн аж ахуйн үйлчилгээний байгууламжууд*

Тус компани нь нийгмийн хариуцлагатай уул уурхайн төслийн хүрээнд өөрийн ажиллагсад төдийгүй Цогтцэций сумын иргэдийг стандартын шаардлагад нийцсэн ундны цэвэр усаар хангадаг бөгөөд хэрэглээнээс гарсан ахуйн бохир усыг татан зайлуулах, цэвэрлэх үйл ажиллагааг шийдвэрлэсэн болно. Энэ зорилгоор дараах байгууламжуудыг барьж байгуулан, ашиглаж байна. Үүнд:

Ундны ус цэнгэгжүүлэх байгууламж

- Хүчин чадал: 750м$^3$/хоног
- Ус цэнгэгжүүлэх байгууламж нь Цогтцэций сумын хүн ам болон уурхайн ажилчдын хотхоныг цэвэршүүлсэн усаар хангах зорилгоор байгуулагдсан.
- Ус цэвэршүүлэх төхөөрөмжийг Герман улсын Prominent компанид үйлдвэрлэсэн бөгөөд мембран шүүлтүүр бүхий урвуу осмосын зарчмаар ажилладаг.
- Байгалийн усыг чөлөөт ионуудаас 97-98%-иар, бусад хольцноос 99% хүртэл цэвэрлэх боломжтой.

Цогтцэций сум, Цэций хорооллын хэрэглээнээс гарсан ахуйн бохир ус цэвэрлэх байгууламж

- Хүчин чадал: 1200м$^3$/хоног
- Бүрэн автомат цэвэрлэх байгууламж ба 96% хүртэл цэвэрлэх боломжтой.
- 35х20м-ийн талбайтай аваарийн сан- 1ш, 35х20м-ийн талбайтай лагийн сан 1ш, 1400м3-ийн 4 ш шүүрүүлэх талбайтай.
- Чехийн SPR технологитой

Ахуйн хаягдал ус цэвэрлэх байгууламжийн шүүрүүлэх талбайд 2025 онд өргөтгөл хийсэн.

### **1.5. Шатахууны агуулах**

Шатахуун түгээх станцыг Ухаа худаг уурхайд ажиллаж буй техник хэрэгслийг түлшээр найдвартай хангах зорилгоор 2019 онд үйл ажиллагаандаа шилжүүлэн авсан. Шатахуун түгээх станц нь шатахуун далд нөөцлөх 50м$^3$-н багтаамжтай 3, ил 24ш нөөцлөх сав болон тээврийн машин орж гарах, зам шатахуун буулгах хэрэгсэл, технологийн худгууд, хаягдлын сан, шатахуун буулгах талбай, шатахуун түгээгүүрүүд , шатахуун түгээх станцын ажилчдын амрах байр зэргээс бүрддэг.

## 1.6. Уурхайн ажиллагсдын хотхон

2013 оны 1 сард Цогтцэций суманд олон улсын жишигт нийцсэн, боловсролын орчин үеийн Мөрөөдөл нэртэй томоохон цогцолбор болох 640 хүүхдийн дунд сургууль, 144 хүүхдийн цэцэрлэг, 100 хүүхдийн дотуур байр бүхий иж бүрэн байгууламж Өмнөговь аймгийн болон тус компанийн хөрөнгө оруулалтаар байгуулагдаж үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн.

Компанийн ажиллагсдын нийгмийн асуудлыг цогцоор шийдэх бодлогын хүрээнд “Цэций” нэртэй орон сууцны хороолол болон 377 айлын хашаатай бүрэн тохижуулсан ажилчдын гэр хорооллыг барьж байгуулсан. 2014 онд “Цэций” хороололд 480 айлын орон сууц ашиглалтанд орж, нийт 708 айл өрх тус хороололд амьдарч байна. 2024-2026 онд хэрэгжүүлэх 250-300 айлын Цэций 2-А; 2-В төслийг хэрэгжүүлж эхэлсэн.



Зураг 1.8. *Цэций хороолол*

## 1.7. Ухаа худаг Гашуун сухайт, Баруун наран Ухаа худаг чиглэлийн авто зам

“Энержи Ресурс” компани Ухаа Худаг – Гашуун сухайт чиглэлийн 245 км хатуу хучилттай замыг барьж байгуулах ажлыг амжилттай хэрэгжүүлж, 2011 оны 10-р сард ашиглалтад оруулсан. Замыг Засгийн газрын 2013 оны 299-р тогтоолоор 2014 оны 02 сарын 14-нөөс хойш төрийн өмчид шилжүүлсэн бөгөөд авто зам төрийн өмчид шилжсэнтэй холбоотойгоор замын менежмент, засвар үйлчилгээ, аюулгүй байдлын хяналт зэрэг асуудлыг “Гашуун сухайт авто зам” ХХК хариуцан замын үйл ажиллагааны тогвортой байдлыг ханган ажиллаж байна. БН-УХГ чиглэлийн хатуу 30.8км урттай хучилттай авто замыг 2012 барьж ашиглалтанд оруулсан бөгөөд Баруун наран уурхайгаас Ухаа худаг уурхайн НБҮ-т боловсруулах нүүрс тээврийн зорилгоор ашиглагддаг. Тус замын 1.96км урт хэсэг Ухаа худаг уурхайн ТЭЗҮ-д тусгагдсан уурхайн карьерийн ахилтанд орох ба геотехникийн аюултай нөхцөл үүссэн тул тухайн хэсгийг 2024-2025 онд тусгайн зөвшөөрөлтэй талбайн хүрээнд шилжүүлэх ажлыг төлөвлөн гүйцэтгэсэн.



Зураг 1.9. *Хатуу хучилттай нүүрс тээврийн зам*

**1.8. Цагаан хад нүүрс ачиж буулгах талбайн үйл ажиллагаа**

Нүүрс буулгах агуулах болон Гаалийн хяналтын талбай нь Өмнөговь аймгийн Ханбогд сумын Номгон багийн нутагт, Цагаан хад нэртэй газарт орших бөгөөд сумын төвөөс урагш 75км, Гашуун сухайтын хилийн боомтоос 20 гаруй км зайд байрлана. Цагаан хадны нүүрс ачиж буулгах талбайд БНХАУлсад экспортлох нүүрсийг талбайгаас дахин ачиж хилийн шалган нэвтрүүлэх болон гаалийн хяналт-бүрдүүлэлт хийдэг. Энэ талбай нь Энержи Ресурс компанийн эзэмшилд байдаг бөгөөд нийт 37 га талбайг эзэлдэг.



Зураг.1.10. *Цагаан хадны нүүрс ачиж буулгах талбай, ажилчдын шинэ хотхон*

2025 онд Цаган хад дахь ажилчды хотхоныг шинэчлэн байгуулж Өмнөговь аймгийн Ханбогд сум 5-р багийн нутагт 4601100018 нэгж талбарын дугаартай 3 га талбай газар эзэмших захирамж гаргуулсан бөгөөд тус кэмп нь 4-н блок бүхий амралтын байр, спорт заал, авто зогсоол ногоон байгууламж бүхий хотхонг байгуулан ашиглаж эхэлсэн.

“Энержи ресурс” ХХК нь мөн Гашуун сухайтын боомтын ойролцоох Хилийн боомтын онцгой бүрэн эрхэт захиргааны эзэмшил болох Чингэлэгт тээврийн термианалын 25%-д үйл ажиллагаа явуулж байна.

**1.9. Ухаа худаг төмөр замын терминал**

Төмөр замын терминал нь уурхайн урд хэсэг, Тээвэр Ложистикийн засварын төвийн чанх урд, Ухаа худаг уурхайн төмөр замын гогцооны хойд хэсэгт лицензийн хилийн дотор талд байрлах ба талбай нь бүтээгдэхүүн хийсэхээс хамгаалах, тоосжилтын тархалтыг хязгаарлах зориулалтын хашаатай байдлаар байгуулагдсан. Терминал нь нийт 6.4га талбайтай ба цамхагт харуулын байр, авто пүү, хучлага хяналтын тавцан, вагон пүү зэргээс бүрдэнэ.



Зураг.1.11. *Ухаа худаг төмөр замын терминал*

## 2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БАЙГАА ГАЗАР НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

### 2.1. Ухаа худаг орчмын газар нутгийн төлөв байдал газар зүйн онцлог

Таван толгойн нүүрсний ордын Ухаа худаг орчмын нутаг дэвсгэр нь гадаргуугийн хувьд ерөнхийдөө нам уулс, жижиг толгод, талархаг гадаргуу зонхилох ба далайн түвшинөөс дээш 1490-1590 м өргөгдсөн. Төсөл хэрэгжих талбай нь аймгийн төв Даланзадгад хотоос зүүн хойшоо 90 км, Цогтцэций сумын төвөөс баруун урагш 10 км зайтай байрладаг. Тус бүс нутгийн хамгийн өндөрлөг цэгүүд нь Таван толгойн талбайгаас баруун урагш орших Бага уул (1731.1 м), зүүн хойно орших Майга улаан уул (1587.5 м), чанх урагш орших Нэргүй өндөрлөг (1652.2 м), зүүн урд нь байрлах Таван толгой уул (1570 м) зэрэг болно. Хамгийн нам цэгүүдэд Улаан нуур болон бусад нуур тойрмуудын хөндий орно. Голын хөндийнүүд нь ерөнхийдөө өргөргийн чиглэлтэй ба элсэрхэг, шаварлаг хурдсаар дүүргэгдсэн байдаг. Физик газарзүйн мужлалаар цөлийн ландшафттай говийн мужид хамаарах бөгөөд газарзүйн хэлбэр, гадаргуугийн хэв шинжээрээ цав толгод, ухаа гүвээт талын хэв шинжид багтдаг. Энэхүү бүс нутагт газар хөдлөлийн талаар урьд өмнө тусгайлсан судалгаа хийж байгаагүй бөгөөд Монгол орны чичирхийлэл, тектоникийн мужлалаар газар хөдлөлтийн 7 баллын бүсэд оршдог бөгөөд газар хөдлөлийн давтамж нь 1000 жилд хоёр удаа байх магадлалтай.

#### *2.1.1. Уур амьсгал*

Цогтцэций сумын нутаг нь уур амьсгалын хувьд гандуу, дулаан зунтай бүсэд багтдаг байна. Энэ нутаг чийг багатай хуурай дулаавтар мужид хамаарах ба агаар ба хөрсний температурын хоногийн хэлбэлзэл ихтэй, хур тунадас бага учраас нэлээд хуурайшилттай, салхи шуурга ихтэй, улирал нь огцом солигддог. Ухаа худаг орчмын уур амьсгал нь эх газрын эрс тэс нэн хуурай, дулаан хээр-говийн уур амьсгалын ангилалд багтана.

Цогтцэций сум болон Ухаа худаг орчмын нутагт хур тунадас бага ордог. Олон жилийн дундаж нийлбэр хэмжээгээр 125 мм, түүний 97% нь дулаан улиралд хур борооны төрлөөр, үлдсэн 3% нь цас хэлбэртэй хүйтэн улиралд ордог. Хур тунадасны хамгийн их хэмжээ борооны улирлын нэг хоногт 50 мм орчим ордог нь үер ус болох ялангуяа нүүрс угааж баяжуулах үйлдвэрийн орчимд ус тунаж зохисгүй нөлөөлнө. Жилд 20 өдөр бороо, 13 өдөр цастай байдаг. Хур тунадас бага учраас энэ бичил бүс нутагт харьцангуй чийгшил жилийн дунджаар 54%, “хуурай” ангилалд хамрагдаж байна. Хур тунадасны уналт, хүйтэн дулааны горимын дагуу харьцангуй чийгшил 4, 5 дугаар сард хамгийн бага 36-40%, зарим өдөр үүнээс доош “нэн хуурай” байдаг бол цасархаг өвөл, зуны хур борооны үед 57-63% болж ихэсдэг зүй тогтолтой.

#### *2.1.2. Хөрс*

Төслийн талбай орчмын нутаг дэвсгэр нь хөрс газар зүйн мужлалаар Төв Азийн говь цөлийн бүслүүрийн цөлөрхөг хээрийн бор хөрсний бүсэд хамаарагдана. Төслийн талбайн хэмжээнд заримдаг

цөлийн бор хөрс зонхилж, гадаргуугийн харилцан адилгүй байдалтай уялдаж, заримдаг цөлийн сайр чулуурхаг болон заримдаг цөлийн нугархаг хужирлаг хөрс тархсан байна. Заримдаг цөлийн бор хөрс зуны хур бороо ихтэй үед 20-30 см чийглэгдэж, түүнээс доошхи гүнд хуурай байх бөгөөд хөрсөн дэх чийг бороо орсноос хойш 5-12 хоног хадгалагдаж байгаад ууршиж замхарна. Чийгтэй байх хэдэн өдрийн хугацаанд ургамлын ургалт маш эрчтэй явагдаж, хөрсөн дэх биологийн үйл явц идэвхиждэг. Хөрсний өнгөн хэсэг, дээд үеүд нь хүчтэй халж, ургамлын үлдэгдлийн эрдэсжих үйл явц эрчимтэй байдаг.

***2.1.3.*** *Ургамал, амьтны аймаг*

Монголын биогеографийн мужлалаар Таван толгой нь Зүүн Говийн цөлөрхөг талын Галбын говийн дэд районд хамаарагдана. Өөрөөр хэлбэл Ухаа худгийн талбай нь Дорноговийн цөлөрхөг хээрийн тойрогт (Н.Өлзийхутаг, 1989) оршино. Ургамлан бүлгэмдлийг бүрдүүлэхийн хувьд энэ нутагт монгол өвс (Stipa gobica), таана (Allium polyrrhizum), бор бударгана (Salsola passerina), улаан бударгана (Reamauria soongarica), түнтгэр баглуур (Anabasis brevifolia), гялгар дэрс (Achnatherum splendens), шар бударгана (Kalidium foliatun), сибирь хармаг (Nitraria sibirica), зүүн гарын хазаар өвс (Cleistogenes soongarica), хөмүүл (Allium mongolicum), төлөгчдүү бор таар (Ajania nelillous), орог тэсэг (Eurato ceratoides) зэрэг ургамлууд бүрдүүлж байна. Үүний дотроос монгол өвс-таанат бүлгэмдэл, монгол өвс-баглуурт бүлгэмдэл, монгол өвс-бор бударганат бүлгэмдэл, бор бударгана-улаан бударганат бүлгэмдэл, шар бударгана-улаан бударгана-бор бударганат бүлгэмдэл, дэрст бүлгэмдэл, сибирь хармагт бүлгэмдэл зонхилно. Төсөл хэрэгжих талбай нь цөлөрхөг хээрийн нам уулс, цав толгод, дэнж тэгш талын ургамалжил, цөлийн хээрийн гэсэн үндсэн хоёр хэвшлийг бүрдүүлж байна. Үүнд:

Ухаа худаг орчмын газар нутгийн ургамалжилт нь ганд тэсвэртэй сөөг, сөөглөг болон цөлийн олон наст өвслөг ургамлаас бүрдэнэ. Зонхилох сөөг нь боролз-*Ajania fruticulosa*, ахар навчит баглуур-*Anabasis brevifolia*, орог тэсэг-*Eurotia ceratoides*, алтан харгана (улаан харгана)-*Caragana leucophloea*, тарваган харгана (ямаан харгана, алтан харгана)-*Caragana pygmaea* болно. Олон настаас хоёр зүйл хялгана хийгээд хазаар өвс, таана, хөмүүл байна. Түүчлэн тухайн жилийн байгаль цаг уурын онцлогоос хамаарч нэг болон хоёр настууд, мөн хаврын эртний эфимерүүд ургамлын бүлгэмдэлд тодорхой үүрэгтэй оролцоно. Мөн энд монгол өвс, таана голлосон цөлийн хээр, түүний дотор нугархаг шинжтэй дэрс, хармагтай хоолойнууд тааралдана. Харин энд хайлаас, заг зэрэг мод ургадаггүй.

Ухаа худаг цогцолбор орчмын нутаг дэвсгэр нь цөлөрхөг хээрийн бүсэд хамаарах бөгөөд олон янзын биотоп байхгүй, харьцангүй нэг хэвийн тул амьтны олон янз байдал ядмаг. Амьтны аймагт суурин бараадаж амьдардаг зүйлүүд нилээд хувийг эзэлдэг байна. Цогтцэций орчим нь амьтны газарзүйн мужлалаар уулархаг азийн дэд их муж, Монгол төвдийн муж, говийн дэд мужийн хойт говийн тойрогт хамаардаг. Энэ нутагт 11 баг, 21 овог, 48 төрөлд хамрагдах 66 зүйл шувуу тэмдэглэгдсэн байна. Судалгааны олон жилийн мэдээллүүдийг хянан үзэхэд энд 7 баг, 14 овогт хамаарах 42 зүйл хөхтөн тохиолддог байна.

## 2.2 Нийгэм эдийн засгийн төлөв байдал

***2.2.1.*** *Эдийн засаг, нийгмийн өнөөгийн төлөв байдлын хамрах хүрээ, суурь мэдээлэл*

Энэхүү эдийн засаг, нийгмийн өнөөгийн төлөв байдлын үнэлгээнд “Энержи Ресурс ” ХХК –ний Ухаа худаг төсөл хэрэгжиж буй Өмнөговь аймгийн Цогтцэций сумын мэдээллийг орууллаа.

***2.2.2.*** *Цогтцэций сум хүн ам*

Цогтцэций суманд байнгын бүртгэлтэй 10752 иргэн явуулын 12000-16000 иргэн, 3481 өрх аж төрж байна.

***2.2.3.*** *Эрүүл мэнд*

2015 оын байдлаар Цогтцэций сумын эмнэлэг нь 41 ажилтан, үүнээс 11 их эмч байгаа ба 1 эмчид 640 хүн буюу 1000 хүн тутамд 1.5 их эмч ноогдож байгаа бол явуулын хүмүүсийг хамтдан авч үзвэл 1000 хүн тутамд 0.5 их эмч ноогдохоор байна.

***2.2.4.*** *Хөдөө аж ахуй*

Цогтцэций суманд адуу, үхэр, хонь голчлон үржүүлдэг. Малчин өрхийн тоо 2024 оны байдлаар 545 байсан бөгөөд нийт тоологдсон малын тоо 134,800 байсан.

***2.2.5.*** *Хөдөлмөр эрхлэлт, орлогын түвшин*

Цогтцэций суманд 2018 оны байдлаар ажилгүй иргэдийн тоо 9, үүнээс 5 эмэгтэй байна.

***2.2.6.*** *Нийгмийн үйлчилгээний хангамж*

Цогтцэций сумын үйлчилгээний байгууллагын талаар судалгаа байдаггүй бөгөөд вэб сайт дээр сүүлийн жилүүдэд 288 аж ахуй нэгж, жижиг бизнес эрхлэгч 1290 иргэн үйл ажиллагаа явуулж худалдаа үйлчилгээний газрууд жилээс жилд өсөн нэмэгдэж байна.

***2.2.7.*** *Дэд бүтэц*

Цахилгаан хангамж – "Ухаа Худаг" төслийн цахилгаан станц нь аж үйлдвэрийн цогцолбороос гадна сумын төвийн эрчим хүчээр хангадаг.

Ус хангамж – "Ухаа Худаг" төсөл аж үйлдвэри йн цогцолборийн ахуйн болон үйлдвэрийн усны хэрэгцээг хангахаас гадна Цогтцэций сумыг ундны цэвэр усаар хангадаг.

Бохир – Цэций хороолол нь – "Ухаа Худаг" төслийн бохир усны нэгдсэн системд холбогдсон

Зам тээвэр – Цогтцэций сумы төв нь Улаанбаатар – Мандалговь-Даланзадгад чиглэлийн замтай хатуу хучилттай замаар холбогдсон. Сум дотроо хатуу хучилттай замтай. Таван толгой уурхайгаас Гашуун сухайт боомт хүртэл хатуу хучилттай замаар холбогдсон.

***2.2.8.*** *Төслийн үндсэн ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт*

Ухаа Худаг ордоос нүүрс олборлох, боловсруулах, тээвэрлэх төслийн үйл ажиллагаанаас тухайн нутаг дэвсгэр, бүс нутгийн байгаль орчинд үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүдийг 2018-2019 онд болон 2024 онд шинэчлэн боловсруулсан төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээнд тодорхойлсон байдаг. Төсөл хэрэгжиж буй бүс нутагт Энержи Ресурс ХХК-с гадна Эрдэнэс Таван толгой ХК, Таван толгой ХК зэрэг бусад аж ахуй нэгжүүд нүүрсний уурхайн ба тэдгээрт туслах дэд бүтцийн төсөл хэрэгжүүлдэг учраас тухайн газрын хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөөлөл нь хам шинж чанартай юм.

Ухаа Худаг ордоос нүүрс олборлох, боловсруулах, тээвэрлэх төслийн үйл ажиллагаанаас үүсэх үндсэн болон болзошгүй сөрөг нөлөөллүүдийг түүнд өртөх орчноор нь буюу агаар, гадаргын болон газар доорх ус, хөрс, амьтан ургамлын аймгийг хамруулан дараах байдлаар тодорхойлсон байдаг.

**Төслийн байгаль орчны сөрөг нөлөөллийн үнэлгээ**

*Хүснэгт 3.1 Ухаа худаг төслийн үйл ажиллагаанаас үүсэх нөлөөллийн эрчим болон үргэлжлэх хугацаа*

| # | Нөлөөлөл | Нөлөөллийн хэлбэр үйлчлэл | | | | Нөлөөллийн эрчим | | | | Нөлөөллийн үргэлжлэх хугацаа | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Гол нөлөөлөл | | Болзошгүй нөлөөлөл | | | | | | | | | | |
| | | Шууд | Шууд бус | Шууд | Шууд бус | Бага(I) | Дунд(II) | Их(III) | Аюултай(IV) | Түр зуурын | Богино хугацааны | Дунд Хугацааны | Урт хугацааны | Байнгын |
| 1 | Агаарын чанар | 10 | 0 | 3 | 1 | 3 | 3 | 8 | 1 | 2 | 4 | 2 | 7 | 0 |
| 2 | Газрын гадарга, газрын хэвлийн тогтоц | 9 | 2 | 0 | 0 | 1 | 6 | 4 | 0 | 1 | 2 | 3 | 2 | 3 |
| 3 | Гадаргын ус | 1 | 3 | 0 | 4 | 2 | 6 | 0 | 0 | 0 | 5 | 1 | 1 | 1 |
| 4 | Газрын доорх ус | 3 | 0 | 1 | 4 | 1 | 3 | 3 | 1 | 0 | 2 | 2 | 2 | 2 |
| 5 | Хөрсөн бүрхэвч | 9 | 0 | 3 | 9 | 1 | 17 | 3 | 0 | 0 | 3 | 2 | 14 | 2 |
| 6 | Ургамлан нөмрөг | 2 | 2 | 1 | 8 | 1 | 8 | 4 | 0 | 0 | 0 | 0 | 13 | 0 |
| 7 | Амьтны аймаг | 2 | 1 | 1 | 4 | 4 | 3 | 1 | 0 | 0 | 0 | 0 | 4 | 4 |
| Нийт нөлөөллийн тоо | | 36 | 8 | 12 | 30 | 13 | 46 | 23 | 2 | 1 | 16 | 10 | 43 | 12 |
| Хувь % | | 14.2 | 3.1 | 4.7 | 11.9 | 5.1 | 18.2 | 9.1 | 0.8 | 0.4 | 6.3 | 3.9 | 17.0 | 4.7 |




Зураг 3.1. *Төслийн үйл ажиллагаанаас газар доорх усанд нөлөөлөх нөлөөллийн цар хүрээ*




Зураг 3.2. *Төслийн үйл ажиллагаанаас үүсэх тоосжилтын цар хүрээ*




Зураг 3.3. *Төслийн үйл ажиллагаанаас хөрсөнд үзүүлэх нөлөөллийн цар хүрээ*




Зураг 3.4. *Төслийн үйл ажиллагаанаас ургамлан бүрхэвчид үзүүлэх нөлөөллийн цар хүрээ*

## 3. УХАА ХУДАГ ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ ТҮҮНИЙ ГОЛ ЗОРИЛТ

Өмнөговь аймгийн Цогтцэций суманд орших Ухаа худагийн ордоос нүүрс олборлох, боловсруулах, тээвэрлэх төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа БОАЖ-н сайдын 2019 оны 10 сарын 29-ний өдрийн А-618 тушаалаар батлагдсан "Байгаль орчны менежмент төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам"-г баримталсан.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэх бөгөөд байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд байгалийн нөөц баялгийг ашиглах явцад байгаль орчныг доройтохоос урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, үлдэгдэл нөлөөллийг дүйцүүлэн хамгаалах, нөхөн сэргээх, нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох, түүх соёлын өвийг хамгаалахтай холбогдсон арга хэмжээг тодорхойлон, шаардагдах хөрөнгө зардлыг тооцож, хариуцах этгээд, хэрэгжүүлэх хугацаа, баримтлах хууль, журам, аргачлал, стандартыг тодорхойлж тусгасан. Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрт төсөл хэрэгжүүлэх явцад байгаль орчинд үүсч болзошгүй өөрчлөлтийг хянах, шинжлэх объект, байршил, баримтлах стандарт, арга аргачлал, хугацаа, хариуцах этгээд, хяналт шинжилгээний үр дүнг тайлагнах талаар тусгахаар хуульчлагдсаныг баримтлан боловсруулав.

Энэхүү төлөвлөгөөний гол зорилтуудыг Ухаа худаг төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний зөвлөмж, тайлант оны байгаль орчны менежмент төлөвлөгөөний хэрэгжилт болон түүнийг тодорхойлж үнэлгээ өгсөн орон нутгийн холбогдох ажлын хэсгийн дүгнэлт, байгаль орчны төлөвлөгөөт аудитын зөвлөмж, ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөө зэрэг баримт бичгүүд дээр үндэслэн тодорхойлов.

"Энержи Ресурс" ХХК-иас Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутаг дэвсгэрт хэрэгжүүлэх Ухаа худагийн уурхайгаас нүүрс олборлох, боловсруулах, тээвэрлэх төслийн 2026 оны байгаль орчны менежментийн гол зорилтууд нь дараах байдлаар тодорхойлогдоно. Үүнд:

- Уурхайн тоосжилтын хяналтыг сайжруулж, хариу арга хэмжээг чанаржуулах
- Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд мод сөөг тарьж ургуулах
- Хаягдал чулуулгийн овоолго дээр техникийн болон биологийн нөхөн сэргээлт үргэлжлүүлэн хийх
- Хог хаягдал булшлан устгах ландфиллын эхний ээлжийг ашиглалтанд оруулах

Энэ оны байгаль орчны менежмент төлөвлөгөөнд тусгасан ажлуудыг төлөвлөхдөө "Ухаа худаг" уурхайн 2026 оны батлагдсан уулын ажлын төлөвлөгөөнд үндэслэсэн болно.

Байгаль орчны менежмент төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээг хэрэгжүүлэхэд 2026 онд нийт 522.7 сая төгрөг шаардагдах бөгөөд "Энежи Ресурс" ХХК байгаль орчныг хамгаалах талаар хүлээсэн үүргээ биелүүлэх баталгаа болгож, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын нөхөн сэргээлтийн тусгай дансанд тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын 50 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг байршуулсан болно.

Энэхүү төлөвлөгөөнд тусгагдсан зардал нь байгаль орчныг хамгаалах, сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний урьдчилан тодорхойлогдох боломжтой хэсэг бөгөөд шууд гүйцэтгэлээр тодорхойлогдох, үйлдвэрлэлийн зардлаар хийгдэх зарим ажлуудын зардлыг энд оруулаагүй болно.

# 4. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

## 4.1. Ухаа худаг төслийн сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

| № | Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ | Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ | Хэмж их нэгж | Нэгжийн зардал, мян.төг | Тоо хэмжээ | Нийт зардал, мян. төг | Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж | Баримтлах эрх зүйн баримт бичиг |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
| 1. | Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөл | Замаас үүсэх тоосжилтыг бууруулахын тулд хурдны хязгаарт хяналт тавих, зам усалгааг хийж гүйцэтгэх | Ил уурхай, Ухаа худаг НАБТ | $м^3$/сар | Үйлдвэрлэлийнзардлаас | 30,000.0 | Үйлдвэрлэлийн зардлаас | Дулааны улиралд өдөр бүр усалгаа хийх | Агаарын тухай хууль, MNS 4585:2025 |
| 2. | | Уурхайн технологийн зам шинээр тавих болон түүний засвар үйлчилгээнд тоосжилт бага үүсгэдэг материалыг сонгож ашиглах | Ил уурхай | м3 | Үйлдвэрлэлийн зардлаас | 25000 | Үйлдвэрлэлийн зардлаас | Уурхайн замын арчилгаа, засвар хийх үед | Агаарын тухай хууль, MNS 4585:2025 |
| 3. | | Хүйтний улиралд тоосжилт бууруулах арга хэмжээ зохион байгуулах | Ил уурхай | ш | - | 1 | 35.400.0 | 1-3 сард | MNS 4585:2025 |
| 4. | | Нүүрсний шаталт уугилтыг тухай бүр бууруулж агаарын бохирдлоос эргийлэх | Нүүрсний овоолгууд | - | Үйлдвэрлэлийн зардлаас | - | Үйлдвэрлэлийн зардлаас | 1-12 сард тухай бүр | Агаарын тухай хууль |
| 5. | | Бутлуурын үйл ажиллагаанаас үүсэх тоосжилтоос урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх | Бутлуур орчимд | ш | Үйлдвэрлэлийн зардлаас | 1 | Үйлдвэрлэлийн зардлаас | 5-6 сард тухай бүрт нь | Агаарын тухай хууль |
| 6. | | R22 фреоноор ажилладаг эйркондейшныг 410A фреон ордог 3 ширхэг эйркондейшноор шинээр сольж агаар мандалд үүсгэх хорт хийг бууруулах | Уурхайн Засварын төв | ш | Үйлдвэрлэлийн зардлаас | 3 | Үйлдвэрлэлийн зардлаас | 5 сард | Агаарын тухай хууль |
| 7. | | Агаар мандалд ялгарах нарийн үнсийг бууруулах зорилгоор Цахилгаан статик | Цахилгаан станц | ш | Үйлдвэрлэлийн зардлаас | 4 | Үйлдвэрлэлийн зардлаас | 10 сард | Агаарын тухай хууль |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | шүүлтүүр №2-ын 1–4 дүгээр секцэд их засвар хийж, бүтээмжийг нэмэгдүүлнэ. | | | | | | | |
| 8. | | Гадна талбайн тоосжилт бууруулах зорилгоор явган хүний замыг сайжруулах, шинээр хийх | Цахилгаан станц | м | Үйлдвэрлэлийн зардлаас | 200 | Үйлдвэрлэлийн зардлаас | 7 сард | Агаарын тухай хууль |
| 9. | | Агаарт дэгдэх бохирдлыг багасгахын тулд үнс багсрах төхөөрөмжийг үйл ажиллагаанд тогтмол ашиглах | Цахилгаан станц | - | Үйлдвэрлэлийн зардлаас | - | Үйлдвэрлэлийн зардлаас | 6-10 сард | Агаарын тухай хууль |
| 10. | | Хаягдлын далангийн хуурай хаягдлыг хөрсөөр хучиж тоос дэгдэлтийг багасгах | НБҮ хуучин хаягдлын далан | га | 30.000.0 | 3 | 30.000.0 | 3-12 сард | Агаарын тухай хууль |
| 11. | Усан орчинд нөлөөлөх нөлөллийг бууруулах түүний эх үүсдэрийг зохистой хэрэглэх | Дээврийн хур борооны усыг цуглуулан хуримтлуулж ногоон байгууламжийн усалгаанд ашиглах | Цэций хороолол | ш | 10.000.0 | 4 | 40.000.0 | 2-р улиралд | БОННҮ-НТ 2025 хэсэг 6.1 |
| 12. | | Хяналтын цооногуудын амсаруудыг битүүмжлэн хялбар нээх, эвдэх боломжгүй болгоно. | Наймант наймдайн хөндийн хяналтын цооногууд | ш | Үйл ажиллагааны зардлаас | 15 | Үйл ажиллагааны зардлаас | 1-р улиралд | УСБГУЭҮ ОБЭХЭА БДМЖ 3.4.8 |
| **13.** | | Хаягдлыг усгүйжүүлэх үйлдвэрийн үйл ажиллагааг горимын дагуу явуулж НБҮ-ийн технологийн усыг эргэлттэйгээр ашиглаж усны нөөцийг хэмнэх | Нүүрс баяжуулах үйлдвэр | $м^3$ | Үйлдвэрлэлийн зардлаас | 1,200,000 | Үйлдвэрлэлийн зардлаас | 1-12 сард Үйлдвэр ажиллах хугацаанд | Усны тухай хууль |
| 14. | | Цахилгаан станцын технологийн хаягдал усыг ногоон байгууламж ба зам талбайн усалгаанд дахин ашиглана. | Цахилгаан станц | $м^3$ | Үйлдвэрлэлийн зардлаас | - | Үйлдвэрлэлийн зардлаас | 5-9 сард | Усны тухай хууль |
| 15. | | Булгийн эх болон уст цэгүүдийг цэвэрлэх арга хэмжээ зохион байгуулна. | Булгийн эх, Хээрийн булаг | ш | Үйлдвэрлэлийн зардлаас | 1 | Үйлдвэрлэлийн зардлаас | 9 сард | Усны тухай хууль |
| 16. | | Цэвэрлэх байгууламжийг горимын дагуу ажиллуулах, саарал усыг зам усалгаад ашиглах | Цэвэрлэх байгууламж | $м^3$ | Үйлдвэрлэлийн зардлаас | 10,000 | Үйлдвэрлэлийн зардлаас | 1-12 сард Үйлдвэр ажиллах хугацаанд | Усны тухай хууль |
| 17. | Амьтны аймагт | 10 кВ-ын агаарын шугамд төлөвлөгөөт үзлэг хийж, шувуу хамгаалах бүрээс, | Наймдай (20 к, Ус | км | 30.000.0 | 71 | 30.000.0 | 6 сард | Амьтны тухай хууль |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | үзүүлэх сөрөг нөлөөлөл | үргээгчийн бүрэн бүтэн байдал, ажиллагааг шалган засварлана. | хангамж (42 км), чиглэлүүдийн шугамууд | | | | | | |
| 18. | | Уулын туруутан амьтдад зориулсан биотехникийн арга хэмжээ хэрэгжүүлэх | Хөх овоо, Тугийн цохио болон Хангинах уул | Боодол | 50.0 | 40 | 2000.00 | 3-р сард | Амьтны тухай хууль |
| 19. | Ургамлан нөмрөг үзүүлэх сөрөг нөлөөлөл | Мод тарьсан талбайн ногоон байгууламжийн усалгаа арчилгаа хийх | Кэмпээс уурхай явах зам дагуу,үйлдвэрлэлийн бүс,ажилчдын хотхон ногоон байгууламж | ш | 15.000.0 | 243,787 | 15.000.0 | 5-10-р сард | ХХЦСТ хууль, Газрын тухай хууль |
| 20. | | Нөхөн сэргээлт, орчны тохижилтонд зориулж мод, сөөг үржүүлж бойжуулах | Мод үржүүлэг туршилт судалгааны талбай | ширхэг | 1000.0 | 30.000.0 | 30.000.0 | 5-9-р сард | MNS 6141:2020 MNS 6252:2011 MNS 6253:2011 MNS 6254:2011 |
| 21. | Хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөлөл | Асгаралт үүсэх эрсдэлтэй талбайд асгаралтын эсрэг багаж, материалын иж бүрдлийг бэлэн байлгах | Үйлдвэрлэлийн бүсэд | ш | 2,500.0 | 5 | 12.500.00 | Жилийн турш | - |
| 22. | | Зам ашиглалтаас үүдэлтэй хөрсний элэгдэл эвдрэлээс урьдчилан сэргийлэх бууруулах | Төслийн талбай болон түүний ойр орчим | км | Үйл ажиллагааны зардал | - | Үйл ажиллагааны зардал | 4-10-р сар | Газрын тухай хууль 56-р зүйл 56.2 Хөрс |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль 6, 7-р зүйл |
| 23. | Хаягдлын овоолгын тэлэлтээс хөрс элэгдэл эвдрэлд орох | Үржил шимт хөрсийг стандартын дагуу хуулж, хадгалах ба уг үйл ажиллагаанд хяналт тавих. | Хаягдлын овоолго | $м^3$ | Үйл ажиллагааны зардал | 300,000 | Үйл ажиллагааны зардал | Шимт хөрсний хуулалт ба хадгалалт стандарт хангасан байх | MNS 5916:2008 |
| 24. | Нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөлөл | Иргэдийн тогтвортой амжиргааг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх | Цогтцэций сум | Удаа | Үйл ажиллагааны зардал | 1 | Үйл ажиллагааны зардал | Жилийн турш | Ашигт малтмалын тухай хууль |
| 25. | | Хүүхдийн эрүүл мэндийн үзлэг зохион байгуулах | Цогтцэций сум | Удаа | Үйл ажиллагааны зардал | 1 | Үйл ажиллагааны зардал | 1 удаа | |
| 26. | | Газар тариалан эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх | Цогтцэций сум | Удаа | Үйл ажиллагааны зардал | 1 | Үйл ажиллагааны зардал | 1 удаа | |
| **Нийт** | | | 194.900.0* | | | | | | |

### 4.2. Цагаан хад орчмын сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

| № | Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ | Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ | Хэмжих нэгж | Нэгжийн зардал, төг | Тоо хэмжээ | Нийт зардал, мян төг | Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж | Баримтлах эрх зүйн баримт бичиг |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
| 1. | Агаар мандалд тоосжилт үүсгэх | Дотоод замаас үүсэх тоосжилтыг бууруулах зорилгоор хурдны хязгаарт хяналт тавих, цэвэрлэгээ хийх, шаардлагатай тохиолдолд усалгаа хийх | Ухаа худаг Цагаан хад НАБТ | - | Үйлдвэрлэлийн зардлаас | - | Үйлдвэрлэлийн зардлаас | 1-12-р сард тухай бүр | Агаарын тухай хууль, |
| 2. | | Салхины хаалтны бүрэн бүтэн байдлыг хангах замаар тоосны тархалтыг хязгаарлах | Цагаан хад НАБТ | - | Үйлдвэрлэлийн зардлаас | - | Үйлдвэрлэлийн зардлаас | 9-р сард | Агаарын тухай хууль |
| 3. | | Шаардлагатай замуудыг хайрган хучилттай болгох | Цагаан хадны НАБТ | м2 | Үйлдвэрлэлийн зардлаас | 200 | Үйлдвэрлэлийн зардлаас | 1-12-р сар | Агаарын тухай хууль |
| 4. | Халдварын эрсдэл | Унд ахуйн усны зөөврийн ба түр нөөцлөх савнуудад угаалга цэвэрлэгээ, ариутгал халдваргүйтгэл хийх | Ундны усны дамжлагын цэгүүд | м3 | 500.0 | 80 | 400.0 | 1-12 сард | Эрүүл ахуйн тухай хууль |
| 5. | Хөрсний болзошгүй бохирдол үүсэх | Шингэн хаягдлын цэгийг нөхөн сэргээх ажлыг зохион байгуулах; | Цагаан хад | ш | Үйлдвэрлэлийн зардлаас | 1 | Үйлдвэрлэлийн зардлаас | 5- сард | MNS 5917 : 2008 |
| 6. | Ахуйн хаягдал ус хөрс бохирдуулах, усний нөөцийн ашиглалт | Цэвэрлэх байгууламжийг горимын дагуу ажиллуулах, саарал усны цэвэрлэх байгууламжаас гарсан цэвэршүүлсэн усыг замын усалгаанд дахин ашиглах | Цагаан хад | м3 | Үйлдвэрлэлийн зардлаас | 1500 | Үйлдвэрлэлийн зардлаас | 2-12 сар | MNS4943:2015 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 7. | Ургамлан нөмрөг талхлагдах | Мод сөөг шинээр тарьж ургуулах, усалгаа арчилгаа хийх | Цагаан хад НАБТ, Шинэ кэмп | ш | 8.0 | 300 | 1,600.0 | 5-р сард | Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль, |
| 8. | Зэрлэг амьтадын амьдрах орчинд сөргөөр нөлөөлөх | Зэрлэг амьтад хамгаалах биотехникийн арга хэмжээ зохион байгуулах, | Цагаан хад орчим байгуулсан уст цэг | - | 1,000.0 | 1 | 1,000.0 | 1-12-р сард | Амьтны тухай хууль |
| **Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний нийт зардал, мян.төг** | | | | | 3,000.0* | | | | |

*Үйлдвэрлэлийн зардлаар хийгдэх ажлын зардал нэмэгдээгүй.*

## 5. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

| № | Нөхөн сэргээлтийн зорилт | Нөхөн сэргээлтийн арга хэмжээ | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Нэгжийн зардал, мян.төг | Нийт зардал, мян.төг | Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж | Баримтлах эрх зүйн баримт бичиг |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| 1. | Техникийн нөхөн сэргээлт | Хаягдлын овоолгыг налуулж, хэлбэршүүлэх | га | 10 | Уулын ажлын зардлаас зарцуулах | | 1-12-р сард | Ашигт малтмалын тухай хууль, Уул уурхайн үйл ажиллагаанаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх аргачлал А-138 MNS 5917:2008 MNS 5918:2008 |
| 2. | | Хаягдлын овоолгын хэлбэршүүлсэн талбайг шимт хөрсөөр хучих | га | 10 | Уулын ажлын зардлаас зарцуулах | | 1-12-р сард | |
| 3. | Биологийн нөхөн сэргээлт | Шимт хөрсөөр хучсан талбайг ургамалжуулах, усалгаа арчилгаа хийх | га | 5 | 175,000.0 | 175,000.0 | 5-9-р сард | |
| 4. | Тэрбум мод хөдөлгөөний хүрээнд мод тарих | Ойн хомсдол, доройтлыг бууруулах, мөн цөлжилт болон газрын доройтол, шороон шуурганы сөрөг нөлөөллийг бууруулах зорилгын хүрээнд ойжуулалт, ойн нөхөн сэргээлтийн ажлыг хэрэгжүүлэх | ш | 20.000 | Тэрбум мод хөтөлбөр хэрэгжүүлэх зардлаас зарцуулах | | 5 ба 10-р сард | Монгол улсын ерөнхийлөгчийн 58-р зарлиг |
| 5. | | Суурин газрын экологийн тэнцвэрт байдлыг хадгалах, нэмэгдүүлэх зорилтын хүрээнд | ш | 5000 | Тэрбум мод хөтөлбөр хэрэгжүүлэх зардлаас зарцуулах | | 5 ба 10-р сард | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 6. | “Хашааны эрүүл, ахуй тав тухтай орчин бүрдүүлэх” | Цогтцэций сумын хашаатай айл өрхөд тарьц суулгац олгож амьдарч буй орчноо ногооруулахад дэмжлэг үзүүлэх, мэргэжил арга зүйгээр хангаж ажиллах | ш | 5000 | Тэрбум мод хөтөлбөр хэрэгжүүлэх зардлаас зарцуулах | 5 ба 10-р сард | |
| **Нийт** | | | | | 175,000.0* | | |

**5.1. Уурхайн хаягдлын овоолгын нөхөн сэргээлт**

### 5.1. Уурхайн хаягдлын овоолгын нөхөн сэргээлт

Ухаа худаг уурхайн техник эдийн засгийн үндэслэлд тусгагдсан гадаад овоолгын техникийн ба биологийн нөхөн сэргээлтийн ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх, нөхөн сэргээлтийн ажлыг Монгол улсын холбогдох стандартын шаардлагад нийцүүлэн, зохих аргачлалын дагуу гүйцэтгэж байгаа ба 2025  оны байдлаар нийт 82 га талбайг хэлбэршүүлж, 50 га талбайг шимт хөрсөөр хучих, 12га талбайг ургамалжуулах ажлыг тус тус хийж гүйцэтгэсэн.

2026 оны хувьд 10 га талбайг хэлбэршүүлж техникийн нөхөн сэргээлт хийх, 10 га талбайд шимт хөрсөөр хучиж, 5 га талбайд биологийн нөхөн сэргээлтийг хийж гүйцэтгэх, мөн өмнөх онуудад хийсэн ургамалжуулсан талбайн усалгаа арчилгааг хийхээр төлөвлөж байна. Нөхөн сэргээлтийн ажлыг хаягдлын овоолгын хойд хэсэгт хийх бөгөөд налуугийн хажуугийн өнцөг нь холбогдох стандартын дагуу 18 градусаас ихгүй байна.



Зураг 5.1.1 *Хаягдлын овоолгын нөхөн сэргээлт*

### 5.5. Тэрбум мод хөдөлгөөний хүрээнд мод сөөг тарих

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг хүрээнд 2025 онд Хархорум хот байгуулах ерөнхий төлөвлөлт, хамгаалалтын ойн зурвас байгуулах төлөвлөгөөний дагуу  “Энержи Ресурс” ххк нь 12.000 шилмүүст мод 28.000 навчит модыг А5,А9 блокд хувиарлагдсан 52 га талбай дээр нийт 40.000 ширхэг мод тарих ажлыг ойн мэргэжлийн байгууллагатай хамтран хийж гүйцэтгэсэн. Мөн Хэнтий аймаг Хэрлэн сумын нутаг Өлзийт баг Чандганы талд байрлах Цөлжилт газрын доройтол бууруулах чиглэлд тариалангийн талбайг хамгаалах ойн зурвас байгуулах ажлыг 05-р сарын 10-наас 06-р сарын 18 хооронд 50.000 мянган ширхэг мод тарьж ургуулах ажлыг хийж гүйцэтгэсэн.

2026 онд тэрбум мод үндэсний хөдлөгөөний хүрээнд манай компани Ойн хомсдол, доройтлыг бууруулах, мөн цөлжилт болон газрын доройтол, шороон шуурганы сөрөг нөлөөллийг сааруулах, суурин газрын экологийн тэнцвэрт байдлыг хадгалах,нэмэгдүүлэх зорилтын хүрээнд 30,000 ш мод суулгац тарин, ойжуулалт, ойн зурвасын  ажил хийхээр төлөвлөж байна.



Зураг 5.5.1 *Шинэ Хархорум хот мод тарилтын ажлын зураг*

## 6. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгааллын ажлын хүрээнд Байгаль орчныг хамгаалах тухай хууль болон бусад холбогдох журам, аргачлал, зөвлөмжийн дагуу 2017 онд төслийн нөлөөлөлд өртөх ба дүйцүүлэн хамгаалах шаардлагатай газрын хэмжээг тогтоох, зарим газар нутгуудад биологийн олон янз байдлын суурь судалгаа хийх зэрэг ажлуудыг гүйцэтгэсэн. Өмнөговь аймгийн ЗДТГ-с өгсөн чиглэлийн дагуу 2018 оноос эхлэн Говь гурван сайханы байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаатай дүйцүүлэн хамгааллын чиглэлээр хамтран ажиллаж эхэлсэн. 2019 онд дүйцүүлэн хамгааллын 5 жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, зэрлэг амьтдад зориулсан уст цэг гаргасан, 2021-2024 онд Говь 3 сайханы байгалийн цогцолборт газрын Баянцагааны нуруу болон Цогтцэций сумын Наймдайн хөндийд гар аргаар алт олборлосны улмаас эвдрэлд орж орхигдсон 27 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийсэн.



Зураг 6.1 *Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалал хийж буй я*

Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгааллын төлөвлөлт, мөн төрийн захиргааны байгууллагаас өгсөн чиглэлийн дагуу 2026 онд дараах ажлыг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

| № | Дүйцүүлэн хамгаалах зорилт | Хамгаалах арга хэмжээ | Арга хэмжээний цар, хэмжээ | Тоо хэмжээ | Нэгжийн зардал, мян. төг | Нийт зардал, мян.төг | Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж | Баримтлах эрх зүйн баримт бичиг |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| 1. | Уулын туруутан амьтадыг хамгаалах | Биотехникийн арга хэмжээ хэрэгжүүлэхэд Говь гурван сайханы байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаатай хамтран ажиллах, дэмжлэг үзүүлэх | Говь гурван сайханы БЦГ-н Баяндалай сумын хэсэг | 150 | 3,200.0 | 3,200.0 | 2-3-р сард | БОНБҮ-ний тухай хууль |
| 2. | Булаг, түүний орчмын экосистем, байгалийн нөхөн сэргэх чадамжийг хамгаалах | Булгийн эх хаших хамгаалах ажлыг зохион байгуулж, хөв цөөрмийн урсац тэжээлийг тэтгэх | Баянгийн задгай | 1 | 15,000.0 | 20,000.0 | 8-р сард | Усны тухай хууль |
| 3. | Байгалийн тоорой бүлгэмдлийг хамгаалах | Байгалийн тоорой бүлгэмдлийг хамгаалах зорилгоор байгуулсан хашааны бүрэн бүтэн байдалд хяналт тавьж, шаардлагатай үед засварын ажил гүйцэтгэх болон тухайн талбайд хортон шавж илэрвэл шаардлагатай тэмцлийн арга хэмжээ авч хэрэгжүүлэх | Өмнөговь аймгийн Номгон сум | 2га | 10,000.0 | 10,000.0 | 6-8-р сард | БОНБҮ-ний тухай хууль |
| **Нийт, мян.төг** | | | | | 33,200.0* | | | |

# 7. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Тус компани нь 2009 оноос эхлэн төслийн үйл ажиллагааны нөлөөлөлд өртсөн нийт 11 айлыг нүүлгэн шилжүүлж нөхөн олговор олгосон бөгөөд одоогоор нүүлгэн шилжүүлэх өөр айл өрх байхгүй тул энэ онд дээрх үйл ажиллагаатай холбоотой ажил уг төлөвлөгөөнд тусгагдаагүй болно. Нөхөн олговор олгох ажлын хүрээнд нөлөөллийн бүсийн малчин айл өрхүүдэд өвс, тэжээлийн дэмжлэг үзүүлэхээр төлөвлөв.

| № | Нөлөөлөлд өртөх иргэд | Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний цар, хэмжээ | Тоо хэмжээ | Нэгжийн өртөг, төг | Нийт зардал, төг | Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж | Баримтлах эрх зүйн баримт бичиг |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| **1.** | Цогтцэций сумын малчин өрх | Өвс тэжээлийн дэмжлэг үзүүлэх | Нөлөөллийн бүсийн айл өрх Цогтцэций сум | 6000 ш | Орон нутгийн төсөл хөтөлбөрийн зардлаас | | 2-4-р сард 1 удаа | Ашигт малтмалын тухай хууль |

## 9. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

2009 оноос хойш холбогдох хуулийн шаардлага ба компанийн нийгмийн хариуцлагын ажлын хүрээнд түүх соёлын биет ба биет бус өвийг хамгаалах чиглэлээр олон тооны ажуудыг хийж хэрэгжүүлсэн. 2025 оны хувьд түүх соёлын өвийг хамгаалах чиглэлээр Цэций нутгийн соёлын биет бус өв болох Говь шанхын уртын 3 дууг орчин үед таниулан түгээх, сэргээн алдаршуулахад хувь нэмэр оруулах зорилгоор телевизийн нэвтрүүлэг бэлтгэж түгээх ажлыг хийсэн.

2026 онд түүх соёлын өвийг хамгаалах чиглэлд дараах ажлуудыг хийхээр төлөвлөсөж байна.

| № | Нөлөөлөлд өртөх түүх, соёлын өв | Хамгаалах арга хэмжээ | Арга хэмжээний цар, хэмжээ | Тоо хэмжээ | Нэгжийн зардал, төг | Нийт зардал, төг | Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж | Баримтлах эрх зүйн баримт бичиг |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| 1. | Соёлын биет бус өв | Тэмээчдийн мэдлэг, баярын уламжлалыг хойч үед нь өвлүүлэх Тэмээний баярт зохион байгуулалтад дэмжлэг үзүүлэх | Цогтцэций сумын Тэмээний баяр | - | Компанийн нийгмийн хариуцлагын зардлаас | | Жилд 1 удаа | Соёлын өвийг хамгаалах тухай хууль |
| 2. | | Монгол өв соёл, эрийн 3 наадам, говь нутгийн хувцаслалт, ёс заншлыг ажиллагсаддаа сурталчлах, түгээн дэлгэрүүлэх, хадгалж үлдэхэд хувь нэмрээ оруулах. | Ухаа худаг наадам | - | Компанийн нийгмийн хариуцлагын зардлаас | | 8 сард | Соёлын өвийг хамгаалах тухай хууль |
| 3. | | Соёлын өв тээгч нартай хамтарсан соёлын өвүүдийг таниулсан, түгээн дэлгэрүүлсэн зураг видео дүрсжүүлэлт хийх. | Цогтцэций сум | - | Компанийн нийгмийн хариуцлагын зардлаас | | 7-9 сард | Соёлын өвийг хамгаалах тухай хууль |

## 9. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

| № | Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл | Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ | Арга хэмжээний цар, хэмжээ | Тоо хэмжээ | Нэгжийн зардал, мян.төг | Нийт зардал, мян төг | Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж | Баримтлах эрх зүйн баримт бичиг |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| 1. | Химийн хорт болон аюултай бодис ашиглах, хадгалах үед асгаралт үүсэх | Химийн хорт болон аюултай бодис хадгалж, ашигладаг хэсэг, нэгжүүдэд асгаралт, гоожилтоос урьдчилан сэргийлэх үзлэг, шалгалтыг тогтмол хийх | Ухаа худаг уурхай | 4 | 500.0 | 2,000.0 | Улирал бүр | Химийн хорт болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулах. Ерөнхий шаардлага MNS 6458: 2014 Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам |
| 2. | Агуулахад хадгалагдаж буй хий ялгаруулдаг химийн хорт болон аюултай бодист өртөх | Хийн алдагдал илрүүлэгч автомат төхөөрөмжийг суурилуулах | Химийн бодисын агуулах | 1 | 10,000.0 | | 6-р сард | Химийн хорт болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулах. Ерөнхий шаардлага MNS 6458: 2014 |
| 3. | Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ хэрэгжээгүйгээс аюул осол гарах | Химийн хорт болон аюултай бодисын аюул, ослын үед ажиллах төлөвлөгөөний дагуу практик сургалт хийх | Ухаа худаг уурхай | 1 | Үйл ажиллагааны зардлаас | | 9-р сард | Химийн хортой ба аюултай бодисын тухай хууль |
| 4. | Химийн бодисын хаягдал, сав, баглаа боодол энгийн хог хаягдалтай хаягдаж хөрс, хүн хордуулах | Химийн бодисын хаягдал, сав, баглаа боодлыг эрх бүхий байгууллагад хүргүүлж устгуулах | Уурхайн хэмжээнд | 30 | 100.0 | 3,000.0 | 10-р сард | Химийн хортой ба аюултай бодисын тухай хууль |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 5. | Ажиллагсдын мэдлэг дутуугаас аюул эрсдэлд өртөх | Химийн бодистой харьцаж ажилладаг ажиллагсдыг сургалтанд хамруулах | Ухаа худаг уурхай | 1 | Үйл ажиллагааны зардлаас | 9-р сард | Химийн хортой ба аюултай бодисын тухай хууль |
| 6. | Гамшгийн онцгой нөхцөл байдал тохиолдох | Гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдлийг бууруулах төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх | Ухаа худаг уурхай | 1 | Үйл ажиллагааны зардлаас | Улиралд 1 удаа | Гамшгаас хамгаалах тухай хууль 4 дугаар зүйл 4.1.20 |
| 7. | Галын аюулгүй байдал хангагдахгүй байх буюу гал унтраах системийн үйл ажиллагаа доголдох | Уурхайн галын дохиолол, гал унтраах автомат систем шинэчлэх | Ухаа худаг уурхай | 1 | Үйл ажиллагааны зардлаас | 10-р сард | Галын аюулгүй байдлын тухай хууль, Барилгын норм ба дүрэм БНбаД-н 21-04-05 |
| 8. | Гамшгийн аюулт үзэгдэл, Гал түймрийн аюул эрсдэл тохиолдох | Аюулт үзэгдэл, ослоос урьдчилан сэргийлэх практик болон онолын сургалтыг нийт ажилтнуудад орох | Ухаа худаг төсөл | 1 | Үйл ажиллагааны зардлаас | 4-10-р сар | Гамшгаас хамгаалах тухай хууль,<br>Галын аюулгүй байдлын тухай хууль |
| 9. | Галаас хамгаалах анхан шатны багаж хэрэгслийн бэлэн байдал алдагдах | Галын аюулаас урьдчилан сэргийлэх үзлэг шалгалтыг тогтмол хийх | Ухаа худаг төсөл | Сар бүр | Үйл ажиллагааны зардлаас | Сар бүр | Галын аюулгүй байдлын тухай хууль, MNS:5566-2020 стандарт |
| 10. | Болзошгүй осол эрсдэл | Цаг агаарын урьдчилан сэргийлэх мэдээг нийт ажилчдад мэдээлэх | Ухаа худаг төсөл | Тохиолдол бүрт | Үйл ажиллагааны зардлаас | Жилийн турш | Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хууль |
| Нийт зардал | | | | | 15,000.0* | | |

**Зураг 10.1 Химийн бодисын эрсдлийн менежментийн үндсэн зарчим**



## 10. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

| № | Хог хаягдлын ангилал | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ | Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ | Хэмжих нэгж | Нэгжийн зардал, мян. төг | Тоо хэмжээ | Нийт зардал, мян.төг | Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж | Баримтлах эрх зүйн баримт бичиг |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
| 1. | Энгийн хог хаягдал | Хуванцрын хог хаягдлыг ангилан ялгах | Хог хаягдал түр хадгалах цэгүүд | $м^3$ | 10.0 | 300 | 3,000.0 | 1-12-р сард | Хог хаягдлын тухай хууль |
| 2. | | Зам талбайд хийсч тарсан хог хаягдлын цэвэрлэгээ зохион байгуулах, Бүх нийтийн цэвэрлэгээнд оролцох | Төслийн талбай Цагаан хад НАБТ Ажилчдын хотхон | удаа | 200.0 | 4 | 800.0 | Улирал бүр | Хог хаягдлын тухай хууль |
| 3. | | Дахин ашиглагдах мод, төмөр зэрэг хаягдлыг 2-догч түүхий эд авдаг аж ахуйн нэгж байгууллагад нийлүүлэх. | Хог хаягдал түр хадгалах цэгүүд | $м^3$ | Үйл ажиллагааны зардлаас | 200 | Үйл ажиллагааны зардлаас | 1-12-р сард | Хог хаягдлын тухай хууль |
| 4. | | Хаягдал дугуйг эрх бүхий байгууллагад шилжүүлэх | Хогийн цэг | ш | Үйл ажиллагааны зардлаас | 5000 | Үйл ажиллагааны зардлаас | 1-12 сард | Хог хаягдлын тухай хууль |
| 5. | | Хог хаягдлын устгалын ландфиллын 1-р ээлжийг байгуулах | Хогийн цэг | ш | Үйл ажиллагааны зардлаас | 1 | Үйл ажиллагааны зардлаас | 1-12 сард | Хог хаягдлын тухай хууль |
| 6. | | Хүнсний хаягдлыг дахин ашиглах | Хоол үйлчилгээ, Оффис-н цайны өрөөнүүд | ш | Үйл ажиллагааны зардлаас | 3 | Үйл ажиллагааны зардлаас | 1-12 сард | Хог хаягдлын тухай хууль |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 7. | | Усны хуванцар савны таглааг ангилан ялгах хогийн савыг байршуулж, таглааг хоёрдогч түүхий эд авдаг газарт нийлүүлэх | Цахилгаан станц | кг | Үйл ажиллагааны зардлаас | - | Үйл ажиллагааны зардлаас | 6 сард | Хог хаягдлын тухай хууль |
| 8. | Аюултай хог хаягдал | Аюултай хог хаягдлыг шаардлага хангасан нөхцөлд хадгалж, нийлүүлэгчид буцаан хүргүүлэх | Уурхайн засварын төв, 1тн ээзлхүүнтэй IBC сав | ш | 10.0 | 400 | 4,000.0 | Улирал бүр | Хог хаягдлын тухай хууль |
| 9. | | Хаягдал тосыг цуглуулж дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлэх | Засварын төвүүд | тн | 10.0 | 300 | 3,000.0 | Сар бүр | Хог хаягдлын тухай хууль |
| 10. | | Засварын төвийн хаягдал тос цуглуулах 2 ширхэг нөөцлүүрийн газар дээрхи талбайг бетондож асгаралтаас сэргийлэх | Уурхайн засварын төв | м2 | 70,000 | 150.0 | 10,500.0 | 1-12 сард | Хог хаягдлын тухай хууль |
| 11. | | Аюултай хог хаягдал болох аккумляторыг нийлүүлэгч болон эрх бүхий байгууллагад хүргүүлэх | Засварын төв | ш | Үйл ажиллагааны зардлаас | 200 | Үйл ажиллагааны зардлаас | Жилд 1 удаа | Хог хаягдлын тухай хууль |
| 12. | | Е- Хог хаягдлын ангилан ялгалтыг эх үүсвэр дээр хийх, эрх бүхий байгууллагад шилжүүлэх зохицуулалт хийх | Бүх алба хэлтэс | Удаа | 4,000.0 | 1 | 4,000.0 | 1-12 сард | Хог хаягдлын тухай хууль |
| **Нийт зардал** | | | 25,300.0* | | | | | | |

### 10.1. Хог хаягдлын менежментийн үндсэн зарчим

Ухаа худаг төслийн хог хаягдлын менежментийн үндсэн зарчим нь дараах байдлаар тодорхойлогдоно.




Зураг 10.1 Хог хаягдлын менежментийн үндсэн зарчим

Түүнчлэн хог хаягдлын менежментийн 5R (Refuse–Reduce–Reuse–Recycle–Recovery) зарчмыг үйл ажиллагааны чиглэл бүрээс үүсэх хаягдалд хамааруулан баримтлахыг зорьж байгаа ба энэхүү зарчим нь уурхайн үйл ажиллагааг байгальд ээлтэй, эдийн засгийн хувьд үр ашигтай, нийгмийн хариуцлагатай болгох нэгдсэн тогтолцоо юм.

5R хог хаягдлын нэгдсэн тогтолцооны хүрээнд бид дараах арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд: химийн бодисын хэрэглээг хамгийн бага түвшинд бууруулах, чанарын үзүүлэлт харилцан адилгүй нүүрсийг хооронд нь холих зарчмаар чанарын шаардлагад нийцсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, говийн нөхцөлд усны ашиглалтыг оновчтой зохицуулан хамгийн бага хэмжээнд барих, уурхайн үйл ажиллагаанаас үүсэх хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах, хаягдал дугуйг замын хамгаалалт болон дуу чимээ тусгаарлагч болгон ашиглах, хаягдал мод, төмрөөр дахивар бүтээгдэхүүн хийж хэрэглэх, дахивар хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгаж эрх бүхий байгууллагад шилжүүлэн дахин боловсруулалтад оруулах, мөн хоол үйлдвэрлэлээс гарах органик хог хаягдлыг ялзмагжуулан бордоо болгох арга замыг эрэлхийлэн хэрэгжүүлж байна.

10.2. Хог хаягдлын урсгал ба зохицуулалт

Хэсэг нэгжийн үйл ажиллагааны онцлогоос хамааран энгийн ба аюултай хог хаягдлыг эх үүсвэр дээр нь дэд төрлүүдэд ангилан ялгана. Дэд төрлүүдэд багтсан хог хаягдал тус бүрийг өнгөний код бүхий хогийн сав болон тохирох хаяг шошготой тусгай талбайд ангилан цуглуулна. Цуглуулсан хаягдлыг хуулийн шаардлагад нийцүүлэн дахин боловсруулах үйлдвэрт хүргүүлэх, эрх бүхий байгууллагад шилжүүлэх, хуулийн хугацаанд түр хадгалах, зарим сав баглаа боодол болон цэнэглэх боломжтой хаягдлыг нийлүүлэгчид буцаах, хоолны хаягдлаар бордоо хийх гэх зэргээр зохицуулагдаж байна

| № | Хогийн савны өнгөний код | Хаягдлын төрлүүд |
|---|---|---|
| 1. | (ногоон) | Ахуйн хог хаягдал |
| 2. | (шар) | Хуванцар сав, зөөлөн гялгар уут, зөөлөн хуванцар |
| 3. | (улаан) | Тосоор бохирдсон хаягдал, хаягдал тос, тослох материал, химийн бодисын хаягдал, түүний сав, баглаа боодол |
| 4. | (цэнхэр) | Хаягдал цаас, картон цаас |

| | | |
|---|---|---|
| 5. | | Хоолны хаягдал |
| 6 | | Электрон хог хаягдал |

Зарим хаягдлын зохицуулагдаж байгаа жишээг доор дурдвал.

Хуванцар савыг эх үүсвэр дээр байрлуулсан төмөр торон савнуудад ангилан ялгаж цуглуулдаг ба дахивар хаягдлын цэг дээр овор хэмжээг багасгасны дараа эрх бүхий байгууллагад шилжүүлдэг.



Зураг 10.2.1. *Хуванцар сав цуглуулах торон савнууд болон прэсслэсэн хуванцар*

Төслийн үйл ажиллагаанаас үүсч байгаа хаягдал тосыг хөрс болон усанд бохирдол үүсгэхгүйгээр давхар хамгаалалт бүхий зориулалтын танканд цуглуулдаг ба хаягдал тос дахин боловсруулах үйлдвэртэй гэрээн хийн сар бүр хуулийн, журмын шаардлагуудад нийцүүлэн хүргүүлдэг.



Зураг 10.2.2. *Засварын төвүүдийн хаягдал тос цуглуулах танкнууд болон тос хүлээн авдаг техник*

*А*юултай хаягдалд хамаарах хаягдал зай хураагуурууд болон хуруу зайг алба хэсгүүд ангилан ялгаж цуглуулан эрх бүхий байгууллагад хүргүүлж ус хөрс болон хүний эрүүл мэндэд учруулах сөрөг нөлөөллөөс сэргийлж байна.




Зураг 10.2.3. *Хаягдал хуруу зай болон жижиг зай хураагуурыг эх үүсвэр дээр ангилан ялгах савнуудыг байрлуулсан байдал ба цуглуулсан хаягдлыг эрх бүхий байгууллагад шилжүүлэхээр бэлдсэн байгаа нь*

## 11. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

| № | Төлөвлөсөн арга хэмжээ | Урьдчилан тооцсон төсөв мян.төг | Хэрэгжүүлэх хуваарь 2026 он | | | | | | Хариуцсан албан тушаалтан | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Сар 1-2 | Сар 3-4 | Сар 5-6 | Сар 7-8 | Сар 9-10 | Сар 11-12 | | |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 |
| 1. | Байгаль орчны хууль, журмын хэрэгжилтийг хангах зорилгоор дотоод хяналтыг хэрэгжүүлэх | Үйл ажиллагааны зардлаас | | | | | | | Байгаль орчны ажилтнууд | Нийт ажлын байрнууд дээр хуваарийн дагуу үзлэг хяналт хийж, үл тохирвол илэрвэл залруулах |
| 2. | Байгаль хамгаалах тэмдэглэлт өдрүүдэд бүтээлч ажил зохион байгуулах | 6,000.0 | | | | | | | Байгаль орчны ажилтнууд | Байгаль хамгаалах тэмдэглэлт өдөр 3 доошгүй арга хэмжээ зохион байгуулах |
| 3. | Байгаль орчны ажилтнуудыг чадавхижуулах сургалт болон туршлага судлах үйл ажиллагааг зохион байгуулах, хурал, семинар, зөвлөгөөн, хэлэлцүүлэгт оролцох | 10,000.0 | | | | | | | Байгаль орчны хэсгийн ажилтнууд | ISO Стандарт болон ногоон байгууламжийн чиглэлээр, Салбарын чиглэлийн аливаа үйл ажиллагаанд санаачлагатай оролцох |
| 4. | Үйл ажиллагаанаас үүсэх хүлэмжийн хийн ялгаруулалтыг тооцоолох, ISO:14064 стандартыг нэвтрүүлэх | Үйл ажиллаганы зардлаас | | | | | | | Байгаль орчны менежер | - |
| 5. | Туслан гүйцэтгэгч аж ахуй нэгж байгууллагад хяналт тавьж ажиллах | Үйл ажиллагааны зардлаас | | | | | | | Байгаль орчны хэсгийн ажилтнууд | Туслан гүйцэтгэгч аж ахуй нэгж байгууллагад хуваарийн дагуу үзлэг шалгалт хийх |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 6. | Компанийн болон туслан гүйцэтгэгч компаниудын ажилтнуудын дунд байгаль орчны сайн дурын ажил зохион байгуулах | Үйл ажиллагааны зардлаас | | | | | | | Байгаль орчны хэсгийн ажилтнууд | Боловсруулсан хөтөлбөрийн дагуу сайн дурын ажилтнуудад байгаль орчны асуудлуудын талаар болон ххк-ын байгаль орчны үйл ажиллагааны талаар бодит байдал дээр үндэслэн мэдлэг мэдээлэл олгоно. |
| 7. | MNS ISO46001:2019 “Усны үр ашигтай хэрэглээний менежментийн тогтолцоо” стандартыг нэвтрүүлэх | Үйл ажиллагааны зардлаас | | | | | | | Байгаль орчны менежер | - |
| 9. | “Бяцхан экологич” хөтөлбөрийн хүрээнд орон нутгийн сурагчдын байгаль орчны мэдлэг, ухамсрыг нэмэгдүүлэх. | Үйл ажиллагааны зардлаас | | | | | | | Байгаль орчны хэсгийн ажилтнууд | Байгаль орчны чиглэлийн сонирхолыг татаж, хариуцлагатай хандлагыг төлөвшүүлэх зорилгоор орон нутгийн ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад чиглэсэн танин мэдэхүйн, оролцоонд суурилсан үйл ажиллагааг зохион байгуулах. |
| 10. | Ажилтнуудын байгаль орчны нөлөөллийг танин мэдэх, удирдах чадавхыг сайжруулах зохион байгуулалтын арга хэмжээг хэрэгжүүлэх | Үйл ажиллагааны зардлаас | | | | | | | Байгаль орчны хэсгийн ажилтнууд | Компанийн болон гэрээт байгууллагын ажилтнуудын өдөр тутмын үйл ажиллагаатай холбоотой байгаль орчны нөлөөлөл, эрсдэлийг тодорхойлох, бууруулахад чиглэсэн асуумж, toolbox сургалт зэрэг арга хэрэгслээр дамжуулан мэдлэг, чадварыг нэмэгдүүлнэ. Гэрээт байгууллагын байгаль орчны хариуцсан ажилтнуудад мэргэжлийн чиглэлээр дэмжлэг үзүүлнэ. |
| Нийт | | **16,000.0*** | | | | | | | | |

## 12. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

### 12.1 Газрын доорхи усны хяналт шинжилгээ

| № | Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд | Хяналтын цэгийн байршил | Хугацаа ба давтамж | Давтамжийн тоо | Нэгжийн зардал, төг | Нийт зардал, төг | Тайлбар | Баримтлах стандарт, арга, аргачлал |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| 1. | Малчдын гар худгуудын усны түвшин хэмжих | Наймантын хөндий болон Наймдайн хөндий | Сард нэг удаа | 12 | 4,300.0 | | 24 худаг | - |
| 3. | Ашиглалтын хяналтын цооногийн усны түвшин хэмжих | Наймантын хөндий болон Наймдайн хөндий | Сард нэг удаа | 12 | - | | 13 Цооног | - |
| 4. | Газар доорх усны хяналтын цооногуудын усны түвшин хэмжих | Эргэлтийн усан сан орчмын 4 уурхай орчмын хяналтын 3 цооног | Сард нэг удаа | 12 | 5,00.0 | | 7 цооног | - |
| 5. | Малчдын гар худгуудын усны чанарын хяналт, шинжилгээ | Наймант болон Наймдайн хөндий | Жилд нэг удаа | 1 | 1,200.0 | | 20 худаг | MNS 0900: 2018 MNS ISO 5667-11:2024 |
| 6. | Газар доорх усны хяналтын цооногуудаас дээж авах, микро элементийн агуулгыг шинжлүүлэх | Эргэлтийн усан сан орчмын 4 уурхай орчмын хяналтын 3 цооног | Жилд нэг удаа | 1 | 1,700.0 | | 7 дээж | MNS 6148:2008 |
| **Нийт** | | | | **7,700.0*** | | | | |

### 12.2. Агаарын чанарын хяналт шинжилгээ

| № | Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд | Хяналтын цэгийн байршил | Хугацаа ба давтамж | Давтамжийн тоо | Нэгжийн зардал, төг | Нийт зардал, төг | Тайлбар | Баримтлах стандарт, арга, аргачлал |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| 1. | Тоосжилтын нөлөөллийг хянах зорилгоор агаарт агуулагдах нарийн ширхэгт тоосонцорыг хэмжих | Ухаа худаг уурхай, Цогтцэций сум | Сард нэг удаа | 12 | 11,400.0 | | 10 цэг | MNS4585:2025 |
| 2. | Уурхайн орчмын агаарт агуулагдах нарийн ширхэглэгт тоосонцрын агууламжийг хянах | Ухаа худаг уурхай | Өдөр тутам | 365 | 4,300.0 | | 1 цэг | MNS4585:2025 |
| 3. | Төслийн үйл ажиллагаанаас үүдэлтэй дуу шуугиан хянах | Ухаа худаг уурхай, Цогтцэций сум | Жилд нэг удаа | 1 | 400,0 | | 10 цэг | MNS4585:2025 |
| 4. | Гадаад орчны агаарын чанарын \$NO_2$, $SO_2$\ хэмжилт хийх | Ухаа худаг уурхай, Цахилгаан станц, Цэвэрлэх байгууламж, Хогийн цэг Цагаан хад НАБТ, Ажилчдын хотхон | Жилд нэг удаа | 1 | 1,600.0 | | 5 цэг | MNS4585:2025 |
| 5. | Цахилгаан станцын зуух болон халаалтын газруудын зуухнуудын утааны найрлага хэмжилт хийлгэх | Цахилгаан станц, Галлерей, Цэций хороолол, НБҮ | Жилд нэг удаа | 1 | 4,000.0 | | 4 цэг | MNS5919:2008 |
| **Нийт** | | | | **21,700.0*** | | | | |

**12.3. Хөрсний судалгаа**

| № | Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд | Хяналтын цэгийн байршил | Хугацаа ба давтамж | Давтамжийн тоо | Нэгжийн зардал, төг | Нийт зардал, төг | Тайлбар | Баримтлах стандарт, арга, аргачлал |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| 1. | Хөрсний агрохими, цацраг болон хүнд металын шинжилгээ хийлгэх | Шимт хөрсний овоолгууд | Жилд нэг удаа | 1 | 700.0 | | 10 цэг | БОНБҮт ХУУЛЬ |
| 2. | Ухаа Худаг уурхай дэд бүтцийн барилга байгууламж орчмын хөрснөөс микро элементийн дээж авч шинжлүүлэх | Засварын төвүүд, ШТС, Хогийн цэг, Цагаан хад НАБТ | Жилд нэг удаа | 1 | 1,200 | | 14 цэг | MNS5850: 2019 |
| **Нийт** | | | | **1,900.0*** | | | | |

**12.4. Ургамал, Амьтны аймгийн судалгаа**

| № | Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд | Хяналтын цэгийн байршил | Хугацаа ба давтамж | Давтамжийн тоо | Нэгжийн зардал, төг | Нийт зардал, төг | Тайлбар | Баримтлах стандарт, арга, аргачлал |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| 1. | Ухаа Худаг уурхай орчим болон дэд бүтцийн барилга байгууламж, ус олборлолтын талбай орчмын ургамлан бүрхэвчийн ажиглалт хийх | -Наймантын хөндий<br>-Нисэх буудал<br>-Хулсан ус худаг<br>-Шинэ ус худаг<br>-Эргэлтийн усан сан<br>-Цагаан хад кемп<br>-Цагаан хад НАБТ | Жилд нэг удаа | 1 | 5,000.0 | | 7 цэг | БОНБҮтХ, |
| 2. | Амьтны судалгаа хийх | Тугийн цохио, Хангинах орчим Ойн зурвас, ТТНБ | Жилд 1 удаа | 1 | 15,000.0 | | 1 цэг | БОНБҮтХ, |
| 3. | Уст цэг дээр автомат камераар ажиглалт явуулах | Цагаан хад | Жилийн туршид | 1 | 2,000.0 | | 1 цэг | Амьтны тухай хууль |
| **Нийт** | | | | **22,000.0*** | | | | |
| **ОХШХ-н нийт зардал, мян.төг** | | | | **53,300.0*** | | | | |

**13. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ХУВААРЬ**

| № | БОХТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд | Тайлагнах хэлбэр | Мэдээллийн агуулга | Хугацааны тов | Тайлагнах зардал, мян төг | Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ ажилтан | Зохион байгуулах газар |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1. | Цогтцэций сумын иргэд | Ярилцах, Хэмжилт хийх | Байгаль орчны мониторингийн ажилд оролцуулах, хэмжилтийн мэдээлэл танилцуулах | 8 сарын 20 | 3,000.0 | Орон нутгийн харилцааны ажилтан<br><br>Байгаль орчны ажилтан | Цогтцэций сум |
| 2. | Орон нутггийн иргэд | Багийн иргэдийн нийтийн хурал | Компанийн үйл ажиллагаа болон БО-ны ажлын гүйцэтгэл | 10-р сарын 1 | 2,000.0 | ОНХХ | Цогтцэций сум |
| 3. | Компанийн ажилтнууд | Бичгээр | Агаарын суурин станцын гадаад орчны тоосны концентрацийцн хэмжилтийн үр дүнгийн мэдээлэл хүргэх | Сар бүрийн 5-ны өдөр | 1,200.0 | Байгаль орчны ажилтан | Мэдээллийн самбарууд |
| 4. | Олон нийт, сонирхогч талууд | Цахимаар | Компанийн байгаль орчны ажлын гүйцэтгэл | Улирал бүр | 800.0 | Олон нийттэй харилцах ажилтан | Нийгмийн цахим сүлжээгээр |
| | Нийт | | | | **7,000.0*** | | |

## 14. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТӨСВИЙН ЗАДАРГАА

| № | Байгаль орчныг хамгаалах арга хэмжээний төсвийн төрөл | Төлөвлөсөн төсөв сая.төг |
|---|---|---|
| 1 | Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх ба бууруулах арга хэмжээ | 197.9 |
| 2 | Нөхөн сэргээлт | 175.0 |
| 3 | Дуйцуулэн хамгаалах арга хэмжээ | 33.2 |
| 4 | Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох | - |
| 5 | Түүх соёлын өвийг хамгаалах | - |
| 6 | Осол эрсдэлийн менежмент | 15.0 |
| 7 | Хог хаягдлын менежмент | 25.3 |
| 8 | Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ | 16.0 |
| 9 | Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр | 53.3 |
| 10 | Олон нийтэд тайлагнах үйл ажиллагаа | 7.0 |
| **Нийт** | | **522.7** |

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний барьцаа хөрөнгийн 50 хувийг “Энержи Ресурс” компаниас Төрийн сангийн тусгай дансанд байршуулсан болно.

**“БОАД” ХХК**

*Байгаль орчны аудитын мэргэжлийн байгууллага*




# “ЭНЕРЖИ РЕСУРС” ХХК-ИЙН “УХАА ХУДАГ НҮҮРСНИЙ УУРХАЙН ЦОГЦОЛБОР” ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ НИЙЦЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨТ АУДИТЫН ТАЙЛАН – 2025




**Тайланг зөвшөөрсөн:**

“Энержи Ресурс” ХХК-ийн Байгаль орчин, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нийцлийн албаны дарга Д.Батбаяр

**Гүйцэтгэсэн:**

“БОАД” ХХК-ийн захирал О.Алтансүх

**Улаанбаатар хот**
**2025 оны 12 сар**

**ТОВЧ МЭДЭЭЛЭЛ:**

Төслийн нэр: Ухаа худаг нүүрсний уурхайн цогцолбор

Байршил: Өмнөговь аймгийн Цогтцэций сум

Гэрээ: ER-25-737

Бичиг баримт: Байгаль орчны нийцлийн төлөвлөгөөт аудит – 2025

Бэлтгэсэн: “БОАД” ХХК

Бэлтгэсэн огноо: 2025 оны 12 дугаар сарын 17

Хянасан: Байгаль орчны ахлах аудитор, доктор О.Алтансүх

Аудиторууд:

- ~ Усан орчны менежмент О.Алтансүх 2013/001
- ~ Химийн хорт болон аюултай бодисын менежмент Б.Баярмаа 2015/129
- ~ Газар-хөрсөн орчин-нөхөн сэргээлтийн менежмент Д.Даваадорж 2013/025
- ~ Агаарын чанар-хийн ялгаруулалтын менежмент Б.Батдэлгэр 2013/035
- ~ Хог хаягдлын менежмент Н.Оюунчимэг 2015/010
- ~ Биологи-дүйцүүлэн хамгааллын менежмент Т.Нармандах 2015/119

**Бичиг баримтын өөрчлөлтийн тэмдэглэл**

| Хувилбар | Огноо | Өөрчлөх шалтгаан | Өөрчлөлт | Өөрчлөлтийн хувь |
|---|---|---|---|---|
| 1 | 2025-12-02 | Анхны хувилбар | | |
| 2 | 2025-12-17 | Хаалтын уулзалтын дара нэмэлт материалыг Захиалагч талас ирүүлсэн. | Үл нийцлүүдийг Нийцэл болгон өөрчилсөн. | 5% |

**Нууцлал:**

Байгаль орчны аудитын энэхүү тайлан нь “Энержи ресурс” ХХК-ийн өмч бөгөөд бусдад задруулах, түгээх, шилжүүлэх нь “Энержи ресурс” ХХК-ийн эрхийн асуудал юм.

Байгаль орчны аудитын байгууллага нь дараах тохиолдолд аудитын тайлан болон түүнтэй холбогдох мэдээллийг задруулна. Үүнд:

- ~ Шүүхийн байгууллагын шийдвэрээр “Энержи ресурс” ХХК-д албан бичгээр мэдэгдсэний үндсэн дээр
- ~ Төрийн болон төрийн бус байгууллага, иргэний шаардлага, хүсэлтийн дагуу “Энержи ресурс” ХХК-аас албан бичгээр зөвшөөрөл авсны үндсэн дээр
- ~ Дараагийн байгаль орчны аудитыг өөр байгууллагаар хийлгэсэн тохиолдолд тухайн аудит хийгдэж эхэлснээс хойш

Энэхүү аудитын тайлан болон түүний бүрэлдэхүүн хэсгүүд нь “Энержи ресурс” ХХК болон тус байгууллагын ажилтныг аливаа зүйлд буруутгах, шийтгэх үндэслэл болохгүй.

**АГУУЛГА**

БАЙГАЛЬ ОРЧНЫ НИЙЦЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨТ АУДИТ – 2025 ....3
1. УСАН ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН АУДИТ ....11
2. АГААР ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН АУДИТ ....15
3. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДАЛ, ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛЛЫН АУДИТ ....18
4. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН АУДИТ ....21
5. ХӨРСӨН ОРЧИН БА ГАЗРЫН МЕНЕЖМЕНТИЙН АУДИТ ....24
6. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН АУДИТ ....26
7. ХИМИЙН ХОРТ БОЛОН АЮУЛТАЙ БОДИСЫН АУДИТ ....29

**ЗУРАГ**

Зураг 1. Аудитын нээлтийн болон хаалтын цахим уулзалт ....4
Зураг 2. Газар дээрх үзлэгийн нээлт ба хаалтын уулзалт ....5
Зураг 3. Байгаль орчны аудитын үнэлэмжийн хэмжээ ....6
Зураг 4. Байгаль орчны аудитын үнэлэмжийн хэмжээ, чиглэл тус бүрээр ....7
Зураг 5. Байгаль орчны аудитын үр дүнгийн харьцуулалт ....7
Зураг 6. Тахирмаг УМ: Аудитын үнэлэмжийн хувь хэмжээ ....11
Зураг 7. Тахирмаг АМ: Аудитын үнэлэмжийн хувь хэмжээ ....16
Зураг 8. Тахирмаг БТ: Аудитын үнэлэмжийн хувь хэмжээ ....18
Зураг 9. Тахирмаг ХМ: Аудитын үнэлэмжийн хувь хэмжээ ....21
Зураг 10. Тахирмаг ГМ: Аудитын үнэлэмжийн хувь хэмжээ ....24
Зураг 11. Тахирмаг НС: Аудитын үнэлэмжийн хувь хэмжээ ....27
Зураг 12. Тахирмаг ММ: Аудитын үнэлэмжийн хувь хэмжээ ....29

**ХҮСНЭГТ**

Хүснэгт 1. Байгаль орчны аудитын багийн бүрэлдэхүүн ....4
Хүснэгт 2. Байгаль орчны аудитын календарчилсан төлөвлөгөө ....6
Хүснэгт 3. Байгаль орчны нийцлийн аудитын нэгдсэн үр дүн ....7

## ТОВЧИЛСОН ҮГС:

| | |
|---|---|
| БОМТ | Байгаль орчны менежментийн төлөвлөгөө |
| БОМТБТ | Байгаль орчны менежментийн төлөвлөгөө биелэлтийн тайлан |
| БОННҮ | Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ |
| ТЖБОМТ | Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө |

# БАЙГАЛЬ ОРЧНЫ НИЙЦЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨТ АУДИТ – 2025

## Удиртгал:

“БОАД” ХХК болон “Энержи ресурс” ХХК-ийн хооронд байгуулсан ER-25-737 дугаартай “Байгаль орчны аудитын үйлчилгээ үзүүлэх гэрээ”-ний дагуу 2025 оны 10 сарын 14 өдрөөс эхлэн 2025 оны 12 сарын 01-ны хооронд “Энержи ресурс” ХХК-ийн Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутаг дахь “Ухаа худаг нүүрсний уурхайн цогцолбор” төслийн үйл ажиллагаанд 6 хүний бүрэлдэхүүнтэй аудитын баг Монгол Улсын “Байгаль орчныг хамгаалах тухай хууль”-ийн 10[1] зүйл болон аудитын компанийн өөрийн боловсруулсан “Эрсдэлд суурилсан аудитын нарийвчилсан арга зүй”-г мөрдлөг болгон ажиллалаа. Аудитын үр дүнг үнэлэхдээ Нийцэл, Үл нийцэл болон Хугацаа болоогүй гэсэн 3 үнэлэмжийг ашигласан. Аливаа нотолгоогоор гүйцэтгэл нь батлагдсан тохиолдолд *нийцэл*, батлагдаагүй тохиолдолд *үл нийцэл*, хууль эрх зүйн хүрээнд болон гүйцэтгэлийн шатанд үр дүн нь тодорхойлогдох болоогүй эсвэл тухайн шалгуур бодит шалтгааны улмаас гүйцэтгэл нь түр хойшлогдсон тохиолдолд *хугацаа болоогүй* гэсэн үнэлэмжид хамаарна. Байгаль орчны аудитын газар дээрх үзлэгийг 2025 оны 11-р сарын 7-9-ний өдрүүдэд “Энержи ресурс” ХХК-ийн Байгаль орчин, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн албатай хамтран хийв.

## Аудитын зорилго:

“Энержи ресурс” ХХК-ийн Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутаг дахь “Ухаа худаг нүүрсний уурхайн цогцолбор” төслийн үйл ажиллагаанд байгууллагуудын хооронд байгуулсан гэрээний дагуу дараах үндсэн 6 чиглэлд байгаль орчны аудитыг гүйцэтгэв.

1. Усан орчны менежмент
2. Агаарын чанар болон хийн ялгаруулалтын менежмент
3. Хөрсөн орчин, газрын менежмент ба нөхөн сэргээлтийн менежмент
4. Биологийн олон янз байдал, дүйцүүлэн хамгааллын менежмент
5. Химийн хорт болон аюултай бодисын менежмент
6. Хог хаягдлын менежмент

Дээрх чиглэлүүдэд байгаль орчны нийцлийн аудит хийж, дүгнэлт гаргахын зэрэгцээ үл нийцлийг залруулах төлөвлөгөөг боловсруулж, мэргэжлийн зөвлөмж өгөх зорилготой.

## Аудит захиалагч ба түүний оролцоо:

Аудит захиалагч нь “Энержи ресурс” ХХК бөгөөд түүний оролцоо нь дараах эрх, үүргээр хязгаарлагдана. Үүнд:

~ байгаль орчны аудитын үйлчилгээ авахаар эрх бүхий хуулийн этгээдийг сонгох;
~ төслийн техник, эдийн засгийн болон холбогдох бусад үнэлгээ, технологи, бизнесийн үйл ажиллагаатай холбоотой зохих мэдээллийг нууцлахыг гэрээт байгаль орчны аудитын эрх бүхий хуулийн этгээдээс шаардах;
~ байгаль орчны аудитын зөвлөмжид санал өгөх;
~ байгаль орчны аудитын тайланг өмчлөх;
~ аудитын багийн гишүүнийг солих хүсэлт гаргах;
~ шаардлагатай гэж үзвэл экологийн хариуцлагын гэрээгээр хүлээсэн үүргээ даатгуулах;
~ шаардсан баримт бичиг, мэдээллийг гэрээ, төлөвлөгөөнд заасан хугацаанд гаргаж өгөх, ажиллах нөхцөлөөр хангах;
~ байгаль орчны аудитын үйл ажиллагаанд холбогдох аливаа бичиг баримт, тайлан, төлөвлөгөөний үнэн зөвийг хариуцах;

~ байгаль орчны аудитын эрх бүхий хуулийн этгээдийн хүссэн, шаардлагатай бичиг баримтыг гуравдагч этгээдээс гаргуулж өгөх;
~ үл нийцлийг залруулах зөвлөмжийг биелүүлэх;
~ үл нийцлийг залруулах зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн ажлын тайланг тогтоосон хугацаанд аймаг, нийслэлийн байгаль орчны албанд хүргүүлэх;
~ байгаль орчны аудитын үйл ажиллагаанд саад учруулахгүй, хөндлөнгөөс оролцохгүй, аудитын тайланд ямар нэг хэлбэрээр нөлөөлөхгүй байх

### Аудитын багийн ахлагч ба гишүүд:

“БОАД” ХХК-ийн аудиторуудаас бүрдсэн 6 хүний бүрэлдэхүүнтэй аудитын баг ажиллав. Үүнд:

Хүснэгт 1. Байгаль орчны аудитын багийн бүрэлдэхүүн

| № | Овог, нэр | Мэргэжил | Эрдмийн зэрэг | Ажлын жил | Албан тушаал | Аудиторын гүйцэтгэх үүрэг | Аудиторын гэрчилгээ |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | О.Алтансүх | Хүрээлэн буй орчин судлал | PhD | 23 | Ахлах аудитор | Усан орчны менежмент | 2013/001 |
| 2 | Д.Даваадорж | Газарзүй, хөрс судлал | PhD | 18 | Аудитор | Газар ашиглалт, хөрсөн орчин ба нөхөн сэргээлтийн менежмент | 2013/025 |
| 3 | Б.Батдэлгэр | Хэрэглээний физик экологи | PhD | 15 | Аудитор | Агаарын чанар, хий ялгаруулалтын менежмент | 2013/035 |
| 4 | Н.Оюунчимэг | Газарзүй | PhD | 12 | Аудитор | Хог хаягдлын менежмент | 2015/010 |
| 5 | Б.Баярмаа | Химийн инженер, технологи | PhD | 31 | Аудитор | Хими болон аюултай бодисын менежмент | 2015/129 |
| 6 | Т.Нармандах | Хүрээлэн буй орчин судлал | BSc | 10 | Аудитор | Биологийн олон янз байдлын менежмент | 2015/119 |

### Аудитын төрөл:

~ Байгаль орчны нийцлийн төлөвлөгөөт аудит

### Байршил ба хугацаа:

Дараах байршлуудад аудитын үйл ажиллагаа явагдав. Үүнд:

~ Төсөл хэрэгжиж буй газар буюу Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутаг дахь нүүрсний уурхайн төслийн талбай болон “Цагаанхад” нүүрс ачиж-буулгах талбай

Аудитыг 2025 оны 10 сарын 14 өдрөөс эхлэн 2025 оны 12 сарын 01-ны хооронд нийт 46 хоног, газар дээрх аудитыг 2025 оны 11-р сарын 7-9-ний өдрүүдэд гүйцэтгэсэн.




Зураг 1. Аудитын нээлтийн болон хаалтын цахим уулзалт



Зураг 2. Газар дээрх үзлэгийн нээлт ба хаалтын уулзалт

**Аудитын хамрах хүрээ:**

1. Цаг хугацааны хувьд: Нийт 46 хоног
2. Орон зайн хувьд: Ухаа худаг нүүрсний уурхайн цогцолбор

   Цагаанхад нүүрс ачиж-буулгах талбай
3. Бичиг баримтын хувьд: Захиалагч байгууллагаас хангагдсан бичиг баримт ба тухайн байгууллагын цахим хуудас. Гуравдагч этгээдээс бичиг баримт авахгүй, түүнийг аудитын шалгуурт тооцохгүй. Хууль тогтоомжийн хувьд тухайн аудитор өөрийн аудит хийж буй чиглэлийн хууль тогтоомжийг бүрдүүлнэ.
4. Объектын хувьд: Төслийн үйл ажиллагаа явагдаж буй талбай, цех, тасаг
5. Хууль тогтоомжийн хүрээнд:

   Монгол Улсын хууль тогтоомжийг аудитын шалгуур тогтооход ашигласан. Аудитын үйл ажиллагааны хууль тогтоомжийн хүчин төгөлдөржилтийн цаг хугацааны хамрагдалт нь 2025 оны 10 сарын 01 өдөр хүртэлх хугацаагаар хязгаарлахаар тохиролцсон. Өөрөөр хэлбэл, 2025 оны 10 сарын 01 өдрөөс хойших аливаа хууль тогтоомжийн өөрчлөлт, нэмэлт, шинэчлэл зэрэг нь аудитын шалгуурт хамаарахгүй. Түүнчлэн хүчингүй болсон хууль тогтоомжийн аливаа зүйл, заалтыг шалгуур болгохгүй. Мөн 2025 оны 10 сарын 01 өдрөөс өмнө батлагдаад одоог хүртэл хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн заалтууд аудитын шалгуур болно. Түүнчлэн БОУАӨЯ-аар батлагдсан, сүүлийн 2 жилийн БОННҮ, БОМТ нь аудитын шалгуур тогтооход ашиглагдсан.
6. Хуулийн этгээдийн хүрээнд:

   Зөвхөн захиалагч байгууллагын хүрээнд хийгдэх ба туслан гүйцэтгэгч, хانган нийлүүлэгч, бусад гэрээт ажил гүйцэтгэгч нарын үйл ажиллагаанд аудит хийгдэхгүй. Өөрөөр хэлбэл, захиалагч байгууллагад аливаа бараа материал нийлүүлдэг, үйлчилгээ үзүүлдэг байгууллагын үйл ажиллагаа хамаарахгүй ба тухайн байгууллагын захиалагчид нийлүүлсэн бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний гэрээ, бичиг баримтын бүрдэл, нийлүүлсэн бүтээгдэхүүн, үйлчилгээ, түүний тайлан гэх мэтийг үзнэ. Дээрх зүйлст аливаа үл нийцэл илэрвэл түүнийг цаашлуулан гэрээлэгч байгууллагад аудит хийхгүй, зөвхөн үл нийцлийг тайландаа тусгаж, түүнд аудит хийлгэхийг зөвлөмж хэлбэрээр бичнэ.

**Аудитад хамрагдаагүй хэсэг:**

Тус аудитад дараах зүйлс хамрагдаагүй.

~ Цаг хугацааны хувьд газар дээрх аудит хийснээс хойш хугацаанд болсон аливаа үйл ажиллагаа

~ Орон зайн хувьд уурхайгаас өөр газарт болсон аливаа үйл ажиллагаа

~ Бичиг баримтын хувьд гуравдагч этгээдээс бичиг баримт аваагүй, түүнийг аудитын шалгуурт тооцоогүй.

~ Объектын хувьд уурхайн үндсэн болон туслах үйл ажиллагаанд хамааралгүй аливаа объект

- Хууль тогтоомжийн хувьд 2025 оны 10 сарын 01 өдрөөс хойших аливаа хууль тогтоомжийн өөрчлөлт, нэмэлт, шинэчлэл зэрэг нь аудитын шалгуурт хамаарахгүй. Түүнчлэн хүчингүй болсон хууль тогтоомжийн аливаа зүйл заалтыг шалгуур болгоогүй.
- Хуулийн этгээдийн хүрээнд үйлчлүүлэгчээс бусад этгээд хамаарахгүй, мөн үйлчлүүлэгчийн туслан гүйцэтгэгч, ханган нийлүүлэгч, бусад гэрээт ажил гүйцэтгэгч нарын үйл ажиллагаанд аудит хийгээгүй.

**Аудитын төлөвлөгөө:**

Аудитыг дараах гурван үе шаттайгаар гүйцэтгэв.

Хүснэгт 2. Байгаль орчны аудитын календарчилсан төлөвлөгөө

| № | Үе шатууд | Эхлэх | 2025 он | |
|---|---|---|---|---|
| | | | 10 | 11 |
| 1 | Бэлтгэл | 2025-10-14 | ■ | |
| 2 | Газар дээрх аудит | 2025-11-07 | | ■ |
| 3 | Үнэлэмж | 2025-11-10 | | ■ |
| 3 | Тайлан | 2025-12-01 | | ■ |

**Аудитын шалгуур:**

Нийт 496 шалгуур үзүүлэлтээр байгаль орчны нийцлийн аудитыг гүйцэтгэв. Эдгээрээс 308 нь төрийн бодлого, үндэсний хөтөлбөр, үндэсний хууль тогтоомж, холбогдох дүрэм журам, аргачлал, стандартад, 188 нь БОННҮ, БОМТ, өмнөх аудитын үл нийцлийг залруулах ажлын төлөвлөгөөнд туссан.

**Баталгаажсан нотолгоо:**

Аливаа аудитын үнэлэмжийг боловсруулахдаа баталгаажсан нотолгоог үндэслэл болгох бөгөөд нийт 457 багц нотолгоог аудитын явцад цуглуулав.

**Аудитын үнэлэмж:**

Шалгуур бүрийг нотолгоотой уялдуулан үнэлэмжийг боловсруулсан. Нийт 496 шалгуурыг цуглуулсан нотолгоонууд дээр тулгуурлан үнэлэмжийг боловсруулахад дараах байдлаар үнэлэгдэв. Үнэлэмжийн бүртгэл:

- Нийцэл 470 95%
- Үл нийцэл 7 1%
- Хугацаа болоогүй 19 4%

Дээрх 3 үнэлэмжээс байгаль орчны нийцлийн бодит хувийг тооцохдоо хугацаа болоогүй гэсэн үнэлэмжийг оруулах нь зохимжгүй. Иймээс нийцэл ба үл нийцлийн хувиар тооцвол **99:1** болно. Үнэлэмжийн бүтцийг тахирмагаар харуулбал:




Зураг 3. Байгаль орчны аудитын үнэлэмжийн хэмжээ

Үнэлэмжийг аудитын чиглэл тус бүрд үзүүлбэл дараах байдалтай харагдана.




Зураг 4. Байгаль орчны аудитын үнэлэмжийн хэмжээ, чиглэл тус бүрээр

БОАЖС-ын 2019 онд баталсан "Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам"-ын 4.12 заалтын дагуу байгаль орчны менежментийн гүйцэтгэл нь 90%-аас дээш байх ёстой бөгөөд энэ нь босго утгыг илэрхийлнэ.

## Харьцуулалт:

"БОАД" ХХК нь "Энержи ресурс" ХХК-ийн "Ухаа худаг нүүрсний уурхайн цогцолбор" төслийн байгаль орчны нийцлийн аудитыг 2021, 2023 онд хийсэн бөгөөд өмнөх аудитын ажлын үр дүнтэй энэ оны үр дүнг харьцуулав.




Зураг 5. Байгаль орчны аудитын үр дүнгийн харьцуулалт

Өнгөрсөн болон одоо үеийг харьцуулбал, байгаль орчны менежментийн хувьд нийцэл 2% өссөн, үл нийцэл 2% буурсан байна.

## Нийт шалгуур ба эрсдэлийн түвшин:

Хүснэгт 3. Байгаль орчны нийцлийн аудитын нэгдсэн үр дүн

| № | Аудитын чиглэл | Шалгуурын биелэлт | | | Эрсдэлийн түвшин | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Нийцэл | Үл нийцэл | Хугацаа болоогүй | их | дунд | бага | үгүй |
| 1. | Усан орчны менежмент | 125 | 6 | 8 | 0 | 0 | 2 | 4 |
| 2. | Агаар орчны менежмент | 59 | 0 | 1 | 0 | 0 | 0 | 0 |
| 3. | Хөрсөн орчин ба газрын менежмент | 65 | 0 | 2 | 0 | 0 | 0 | 0 |
| 4. | Нөхөн сэргээлтийн менежмент | 29 | 0 | 2 | 0 | 0 | 0 | 0 |
| 5. | Биологийн олон янз байдлын менежмент | 51 | 0 | 3 | 0 | 0 | 0 | 0 |
| 6. | Химийн хорт болон аюултай бодисын менежмент | 82 | 0 | 3 | 0 | 0 | 0 | 0 |
| 7. | Хог хаягдлын менежмент | 59 | 1 | 0 | 1 | 0 | 0 | 0 |
| **Нийт** | | **470<br>95%** | **7<br>1%** | **19<br>4%** | **1<br>15%** | **0<br>0%** | **2<br>29%** | **4<br>56%** |

Нийт 496 шалгуураас 470 нь нийцэл, 19 нь хугацаа болоогүй, 7 нь үл нийцэлтэй гэж үнэлэгдлээ. Эрсдэлийн түвшний хувьд үл нийцлийн 15% нь их, 29% нь бага эрсдэлтэй байна.

### Үл нийцлийн эрсдэл:

Төслийн үйл ажиллагаанаас үүсэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, түүнийг арилгах, бууруулах, хүрээлэн буй орчны байгалийн бүрдэл хэсгүүд, хүний эрүүл мэндийг хамгаалах зорилгоор хэрэгжүүлэх ёстой арга хэмжээ буюу шаардлагуудыг төсөл хэрэгжүүлэгч биелүүлээгүйгээс аливаа эрсдэл үүснэ. Үүнээс улбаалан аюулгүй ажиллагаа, орчны эрүүл ахуй, байгаль орчин бохирдож, доройтох ба хуулийн дагуу хариуцлага хүлээх болно. Эрсдэлийг үнэлэхдээ дараах хэлбэрүүдийг ашиглав.

- ~ Их Тухайн шалгуурыг гүйцэтгээгүйгээс байгаль орчин, хүний эрүүл мэнд, төслийн үйл ажиллагаанд учирч болох эрсдэл өндөр. Аудитын багийн ахлагчид даруй мэдэгдэнэ.
- ~ Дунд Тухайн шалгуурыг гүйцэтгээгүйгээс байгаль орчин, хүний эрүүл мэнд, төслийн үйл ажиллагаанд учирч болох эрсдэл дунд зэрэг.
- ~ Бага Тухайн шалгуурыг гүйцэтгээгүйгээс байгаль орчин, хүний эрүүл мэнд, төслийн үйл ажиллагаанд учирч болох эрсдэл бага.

Байгаль орчны аудитын үл нийцлийн эрсдэлийг үнэлэхдээ өөрсдийн боловсруулсан HEO үнэлгээний аргачлалыг ашиглав. Уг эрсдэлийн үнэлгээ нь:

| | | |
|---|---|---|
| H | Health | Хүний эрүүл мэнд, аюулгүй байдлын индекс |
| E | Environment | Байгаль орчны аюулгүй байдлын индекс |
| O | Operation | Төслийн үйл ажиллагааны хэвийн байдлын индекс |

гэсэн 3 хэсэгт эрсдлийг тохиолдлын давтамж, эрэмбийн матриц, эрсдэлийн индекс зэрэгт тулгуурлан аудиорын мэдлэг, ур чадварт үндэслэн тогтоодог.

Хүний эрүүл мэнд-аюулгүй байдал, байгаль орчны аюулгүй байдал, төслийн үйл ажиллагаанд учруулах эрсдэлийг эрэмбэлэхдээ бага, дунд, их гэж ангилж, тус бүрд нь шар, улбар шар, улаан өнгөөр тэмдэглэнэ.

Хүний эрүүл мэнд, аюулгүй байдлын индекс - **H**ealth

| Тохиолдлын давтамжийн индекс | | Хүний эрүүл, аюулгүй байдалд учруулах эрсдэл | | |
|---|---|---|---|---|
| Тохиолдол/жил | Давтамжийн индексийн тодорхойлолт | Бага | Дунд | Их |
| > 1 | 5. Байнга давтагдах | | | |
| 1/10 - 1 | 4. Дахин давтагдах | | | |
| 1/100 - 1/10 | 3. Нэг удаа тохиолдох боломжтой | | | |
| 1/1000 - 1/100 | 2. Бараг тохиолдохгүй | | | |
| 1/10000 - 1/1000 | 1. Тохиолдох магадлал бараг байхгүй | | | |

Байгаль орчны аюулгүй байдлын индекс - **E**nvironment

| Тохиолдлын давтамжийн индекс | | Байгаль орчны аюулгүй байдалд учруулах эрсдэл | | |
|---|---|---|---|---|
| Тохиолдол/жил | Давтамжийн индексийн тодорхойлолт | Бага | Дунд | Их |
| > 1 | 5. Байнга давтагдах | | | |
| 1/10 - 1 | 4. Дахин давтагдах | | | |
| 1/100 - 1/10 | 3. Нэг удаа тохиолдох боломжтой | | | |
| 1/1000 - 1/100 | 2. Бараг тохиолдохгүй | | | |
| 1/10000 - 1/1000 | 1. Тохиолдох магадлал бараг байхгүй | | | |

Төслийн үйл ажиллагааны хэвийн байдлын индекс - **O**peration

| Тохиолдлын давтамжийн индекс | | Төслийн хэвийн үйл ажиллагаанд учруулах эрсдэл | | |
|---|---|---|---|---|
| Тохиолдол/жил | Давтамжийн индексийн тодорхойлолт | Бага | Дунд | Их |
| > 1 | 5. Байнга давтагдах | | | |
| 1/10 - 1 | 4. Дахин давтагдах | | | |
| 1/100 - 1/10 | 3. Нэг удаа тохиолдох боломжтой | | | |
| 1/1000 - 1/100 | 2. Бараг тохиолдохгүй | | | |
| 1/10000 - 1/1000 | 1. Тохиолдох магадлал бараг байхгүй | | | |

"БОАД" ХХК нь эрсдэлд суурилсан байгаль орчны аудитыг Монгол улсад хөгжүүлэх зорилготой бөгөөд энэ нь захиалагч байгууллагад аль үл нийцэл нь илүү эрсдэлтэй бөгөөд түүнд ач холбогдол өгч залруулахад эрэмбэлэх ач холбогдолтой.

### Санал зөрөлдөөн, саад бэрхшээл, тодорхой бус байдал:

Байгаль орчны аудитын үед ямар нэгэн санал зөрөлдөөн, саад бэрхшээл, тодорхой бус байдал үүсээгүй.

### Аудитын дүгнэлт:

"Энержи ресурс" ХХК-ийн Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутаг дахь Ухаа худаг нүүрсний уурхай төслийн **байгаль орчны үйл ажиллагааны 99% нь үндэсний хууль тогтоомжид нийцэлтэй** байна. Хугацаа болоогүй буюу тухайн шалгуурыг гүйцэтгэх цаг хугацаа болоогүй шалгуурыг шууд үл нийцэл гэж ойлгохгүй бөгөөд тус байгууллага ирээдүйд түүнийг гүйцэтгэнэ гэдэг итгэлтэй байна.

Тус компани нь Монгол Улсын хууль тогтоомжийн биелэлтийг хангаад зогсохгүй олон улсын ISO холбогдох стандартуудын шаардлагыг биелүүлдэг давуу талтай. Үүнд:

1. Монгол улсын Байгаль орчны хууль, дүрэм журам, стандартууд
2. Олон улсын ISO14001 Байгаль орчны стандартын шаардлагад нийцсэн Байгаль орчны удирдлагын тогтолцоог хэрэгжүүлдэг.
3. ISO 46001:2019 "Усны үр ашигтай хэрэглээний менежментийн тогтолцоо" олон улсын стандартыг хэрэгжүүлж, түүнийгээ Тайван улсын AFNOR Asia Ltd байгууллагаар баталгаажуулж байна.

БОАЖ-ын Сайдын 2019 оны А/618 тоот тушаалаар батлагдсан "Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам"-ын 4.15-р зүйлд заасны дагуу **"Энержи ресурс" ХХК-ийн Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутаг дахь "Ухаа худаг нүүрсний уурхай"-н байгаль орчны нийцэл нь 99% байгаа тул 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг үүгээр дүгнэх боломжтой.**

